

БНМАУЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ЭДИЙН  
ЗАСГИЙН УЛСЫН ХОРОО

БНМАУ-ЫН ХҮН АМ, ОРОН  
СУУЦНЫ 1989 ОНЫ ТООЛЛОГО  
ЯВУУЛАХ ЖУРАМ, ТООЛЛОГЫН  
ХУУДАС НӨХӨХ ЗААВАР

УЛААНБААТАР ХОТ—1988

**БНМАУ-ЫН ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 1989 ОНЫ  
ТООЛЛОГО ЯВУУЛАХ ЖУРАМ, ТООЛЛОГЫН  
ХУУДАС НӨХӨХ ЗААВАР**

**НЭГ. Хүн амын тооллогыг явууллах журам**

1. БНМАУ-ын хүн амын 1989 оны тооллогын хүудасны хариулт нь батлагдсан программын дагуу зөвхөн нэгдсэн дүнг гаргахад ашиглагдана.

2. Хүн амын тооллогын хяналтын ўе нь 1989 оны 1 дүгээр сарын 4-нөөс 5-нд шилжих 00 цаг болно.

3. Хүн амын тооллогыг 1989 оны 1 дүгээр сарын 5-ны өглөөний 8 цаг (орон нутгийн цагаар)-аас 9-нийг дуустал 5 өдөрт багтаан явуулна.

4. Тусгай томилогдсон тоологч нар сууц, нийтийн байр, гэрээр орж, хүн бүрээс асуух журмаар тооллогын хуудсыг нөхнө. Харин хүүхэд, хүнд өвчтөн, түр эзгүй байгаа хүмүүсийг тухайн өрхийн (гэр бүлийн) насанд хүрсэн аль нэгэн гишүүнээс лавлан асууж тооллогын хуудсыг нөхнө.

**ТАЙЛБАР:** Манай улсад хөдөө аж ахуйн нэгдлийн өрх, ажилчин, албан хаагчид, бусад иргэдийн гэр бүл гэдэг нь хоёр өөр ойлголт боловч хүн ам, орон сууцны тооллогын хуудсаанд хялбарчлах үүдиээс аль алиныг нь адилтган зөвхөн өрх гэж нэрлэв.

5. Тоологч нар үйлдвэр, аж ахуйн газар, албан байгууллага, сургуулиар явж тооллого явуулахгүй.

6. Тооллогын хуудсаанд хувь хүний регистрийн дугаарыг иргэний баримт (паспорт, төрсний гэрчилгээ, хувийн үнэмлэх)-аас үнэн зөв хуулж бичнэ.

**ТАЙЛБАР:** Тооллогын хуудсыг хүн бүрээс асуух журмаар нөхөн боловч регистрийн дугаарыг үнэн зөв бичихийн тулд хувь хүний иргэний баримтыг үндэслэж байгаа юм.

7. Хүн амын тооллогод БНМАУ-ын харьяат бүх иргэд, тус улсын нутаг дэвсгэрт байнга болон түр оршин суугаа гадаадын харьяат иргэд (Гадаад улсын дипломат төлөөлөгчдийн ба консулын газар, олон улсын байгууллагын ажилтнууд, тэдгээрийн гэр бүлийн хүмүүсээс бусад), харьяалалгүй хүмүүс бүрэн хамрагдана.

8. 1989 оны 1 дүгээр сарын 4-нээс 5-нд шилжих 00 цагийн байдлаар дараах хүмүүсийг тоолно. Үүнд:

а) тухайн сууц, нийтийн байр, гэр (айл өрх)-т байнга амьдрал суудаг бэлэн байгаа болон түр эзгүй (энэ зааврын 109, 110 дугаар зүйлд заасан) хүмүүс;

б) засаг захиргааны хувьд өөр газар харьяалтай боловч тухайн сууц, нийтийн байр, гэр (айл өрх)-т түр суугаа (энэ зааврын 111 дүгээр зүйлд заасан) хүмүүс;

в) иргэний гэр бүлийн байгууллагад бүртгүүлсэн, бүртгүүлээгүй харгалзахгүйгээр хяналтын үеэс өмнө төрсөн хүүхдүүд, хяналтын үеэс хойш тооллогын өдрүүдэд нас барсан хүмүүс; (харин хяналтын үеэс хойш төрсөн хүүхдүүд, хяналтын үеэс өмнө нас барсан хүмүүсийг тооллогод хамруулахгүй)

г) байнга оршин суудаг газраа тодорхой нэрлэж чадахгүй байгаа тухайн сууц, нийтийн байр, гэр (айл өрх)-т бэлэн байгаа хүмүүс.

9. Засаг захиргааны хувьд шилжиж ирээд ирсэн газраа бүртгүүлээгүй байгаа хүмүүс, өөр газар засаг захиргааны харьяалтай боловч тухайн сум, район, ОСГ-ны хороонд б сараас дээш хугацаагаар амьдардаг хүмүүсийг тооллогын үед оршин сууж буй газарт нь байнга суугчаар тоолно.

10. Их, дээд, тусгай дунд, техник мэргэжил, ерөнхий боловсролын сургууль, курс (б сараас дээш хугацаатай)-ын өдрийн ангид суралдагчдыг тухайн сургууль, курс нь байрладаг газар нь байнга суугчаар тоолно.

11. Хугацаат цэргийн албан хаагчид, цэргийн сургуулийн сурагч, сонсогчдыг Батлан хамгаалах яам, Нийгмийг аюулаас хамгаалах яамны дэргэд байгуулагдсан хүн амын тооллогын комисс тоолно.

Харин Батлан хамгаалах яам, Нийгмийг аюулаас хамгаалах яам тэдгээрийн харьяа байгууллагуудад ажиллаж байгаа генерал, офицер, улирсан албан хаагч, сэргийлэгч, гал сөнөөгч, хянагч нарыг оршин суудаг газар нь өнгийн иргэдийн адил тоолно.

4

12. Гадаадад суугаа БНМАУ-ын харьяат иргэдийг тухайн улсад манай улсаас суугаа Элчин сайдын яам, дипломат төлөөлөгчдийн газрын дэргэд байгуулагдсан тооллогын комисс тоолно.

13. БНМАУ-д уригдан ирж ажиллаж байгаа гадаадын харьяат бүх иргэд, тэдгээрийн гэр бүлийн хүмүүс, тэдний урилгаар ирсэн гадаадын харьяат нарыг БНМАУ-ын Гадаад явдлын яамны шугамаар тоолно.

1989 оны 1 дүгээр сарын 4-нээс 5-нд шилжих 00 цагаас өмнө тус нутаг дэвсгэрт орж ирээд галт тэрэг, бусад хөсгөөр тооллогын хугацаанд дамжин яваа гадаадын харьяат нарыг тооллогод хамруулна.

Харин тооллогын хяналтын үе (1989 оны 1 дүгээр сарын 4-нээс 5-нд шилжих 00 цаг)-ээс хойш манай улсын нутаг дэвсгэрт орж ирсэн гадаадын харьяат иргэдийг хүн амын тооллогод хамруулахгүй, мөн хугацаанд орж ирсэн БНМАУ-ын харьяат иргэдийг тооллогод хамрагдсан эсэхийг нь шалгаж, хамрагдаагүй бол хамруулна.

14. Нийгмийг аюулаас хамгаалах яамны дэргэд байгуулагдсан тооллогын комисс ял өдэлж байгаа хүмүүсийг тоолно. Харин жижиг танхайц хэргээр 30 хүртэл хоногиор баривчлагдсан хүмүүс, урьдчилан мөрдөн байцаалтад байгаа хүмүүсийг тоологчид, өөрийн нь өрхөд түр эзгүүгээр, НАХЯ-ны дэргэд байгуулагдсан комисс, хоригдож байгаа газарт нь түр суугаагаар тус тус давхар тоолно.

15. БНМАУ-д байнга оршин суудаг гадаадын харьяат пар, дагаар орж ирсэн болон алъ ч улсын харьяалалгүй хүмүүсийг оршин суудаг газарт нь тус улсын иргэдийн нэгэн адил тоолно.

#### ХОЁР. Хүн ам, орон сууцны тооллогын комиссын ажлын заавар

16. Хүн ам, орон сууцны тооллогын бэлтгэлийг хангах, тооллогыг удирдан зохион байгуулж явуулах үүрэгтэй аймаг, хот, сум, хороо, район, орон шүтгийн хотын тооллогын комиссыг тэдгээрийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны даргаар толгойлуулан аймаг, хотод 25—30 хүн, сум, хороо, район, орон шүтгийн хотод 9—12 хүний бүрэлдэхүүнтэйгээр 1988 оны 10 дугаар сарын 1-нээс эхлэн байгуулж ажиллуулна.

17. Аймаг, хот, сум, хороо, район, орон шүтгийн хотын тооллогын комиссуудыг байгуулагдах хүртэл хүн ам,

5

орон сууцны 1989 оны тооллого явуулах бэлтгэл ажлыг аймаг, хотын Төлөвлөгөө, эдийн засгийн хороо удирдах сум, хороо, район, орон нутгийн хотуудад зохион байгуулна.

18. Тооллогын комисс нь тооллогын бэлтгэлийг хангах, тооллогыг удирдан зохион байгуулж явуулах, дүн гаргах талаар энэхүү зааврын 19—65 зүйлд заасан ажлуудыг хийх тусгай бие даасан төлөвлөгөөтэй ажиллана.

## 2. 1. Аймаг, хотын тооллогын комиссийн ажил

19. Хүн амын тооллогын зорилго, ач холбогдол, тооллого явуулах журам, үүнтэй холбогдуулан албан байгууллага, хөдөлмөрчдөөс түүнд гүйцэтгэх үүргийг сурталчлан таниулна.

20. Хүн амын шилжих хөдөлгөөн, засаг захиргааны харьяалтай холбоотой асуудлыг аймаг, хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаагаар бүрэн шийдвэрлүүлсэн байна.<sup>1</sup>

21. Комиссын гишүүдэд сум, хороо, район, орон нутгийн хотын комиссыг хуваарилан хариуцуулж, бэлтгэлийг хангаж байгаа байдалд нь хяналт тавиулж, шалган туслах ажлыг хийнэ.

22. Хүн ам, орон сууцны тооллогын бэлтгэлийг хэрхэн хангаж байгаа талаар сум, хороо, район, орон нутгийн хотын тооллогын комисс, албан байгууллагын дарга, эрхлэгч пар болон вэрийн гишүүдийн илтгэл, сонсгалыг тооллогын комисс дээр авч хэлэлцэн удирдамж заавар өгнө.

23. Комисс бүр бүх сум, хороодынхоо 50-иас доошгүй хувьд тооллогын бэлтгэлийг хангах талаар зохиож байгаа ажил, үр дүнтэй нь танилцах, холбогдох арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлнэ.

Бэлтгэл ажлын явцад илэрсэн тэргүүний арга ажиллагааг дэлгэрүүлэх, зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээг сум, хороодын комисстай хамтран зохион байгуулна.

24. Тооллогын маягт, урьдчилсан дүнгийн хүснэгт, зааврын хангамж, хүрэлцээг нарийн тооцож, сум, хороо, район, орон нутгийн хотын тооллогын комиссуудад хэрэглэгдэх маягт, заавар, хавтсыг зохих нөөцтэйгээр хүлээгдэн өгнө.

25. Сум, хороо, район, орон нутгийн хотын тооллогын

<sup>1</sup> Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаа зохих журмын гадуур шилжин суурьшсан иргэдийн асуудлыг шийдвэрлэж дууссан байна.

комиссын ажилтын семинарыг аймгийн төв, хотод 1988 оны 11 дүгээр сарын сүүлийн хагаст багтаан зохион байгуулж хийлгэнэ.

26. Тооллогын бэлтгэл ажил, явцыг батлагдсан асуулт, графикаар Төлөвлөгөө, эдийн засгийн улсын хороонд мэдээлж байна.

27. Хүн ам, орон сууцны фондын тооллогын бэлтгэл ажлыг хангуулах, материалыг шалгаж хүлээн авах, дүн мэдээг нэгтгэн гаргаж улсад тушаах үүрэг бүхий орон тооны бус түр товчоог аймаг, хотын тооллогын комиссын дэргэд 9—12 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, 1988 оны 12 дугаар сарын 1-нээс эхлэн ажиллуулна.

28. Сум, хороо, район, орон нутгийн хотуудын АДХ-ын гүйцэтгэх захиргааны тооллогын комиссуудаар тооллогод хамрагдсан бүх хүний 10-аас доошгүй хувд хяналтын тооллого хийлгүүлэх ажлыг зохион байгуулж, биенэлтэд нь хяналт тавина.

29. Тооллогод хамрагдсан эсэх нь тодорхойгүй хүмүүсийн талаар сум, хороо, орон нутгийн хотын комиссуудаас тавьсан асуудлыг шуурхай судлан шийдвэрлэж хариу өгнө.

30. Тооллогын ажлын явцыг төв, орон нутагт сурвалжлах, сурталчлах ажлыг зохион байгуулна.

31. Тооллогын үед ажиллах аймаг хотын комиссын хариуцлагатай жижүүрийг томилох, байрлах контор, телефоныг тохирч, сум, хороо, район, орон нутгийн хотын тооллогын комиссуудад мэдэгдэх, тооллогын түр товчооны ажиллах байр, хэрэгцээт материал хэрэгсэл (тооны машин, сейф, бичгийн хэрэгсэл гэх мэт)-ээр хангах ажлыг зохион байгуулна.

32. Тооллогод хэрэглэх унаа гаргуулах, зохицуулах, түүнтэй холбогдсон бусад ажлыг зохицуулан шийдвэрлүүлнэ.

33. Сум, хороо, район, орон нутгийн хотуудад хүн ам, орон сууцны тооллого явуулах ажилд хяналт тавьж туслах, аймаг, хотын төлөөлөгчдийг томилж, удирдамж заавраар хангана.

34. Сум, хороо, район, орон нутгийн хотын тооллогын комиссын ажилд үнэлэлт дүгнэлт өгч, аймаг, хотын хэмжээнд хүн ам, орон сууцны тооллогыг зохион байгуулж явуулсан дүнгийн тухай илтгэх хуудас бичиж Төлөвлөгөө, эдийн засгийн улсын хороонд хүргүүлнэ.

## **2. 2. Сум, хороо, район, орон нутгийн хотын тооллогын комиссоос хийх ажил**

**35.** Хүн амын тооллогын зорилго, ач холбогдол, тооллого явуулах журам, үүнтэй холбогдуулан албан байгууллага, хөдөлмөрчдөөс гүйцэтгэх үүргийн талаар сурталчлан таниулах ажлыг төлөвлөгөөтэйгээр зохион байгуулна. Үнд:

а) тооллогын улс төр, нийгэм-эдийн засгийн ач холбогдлыг хөдөлмөрчдөө өргөн таниулах;

б) тооллогод хүн бүрийг бүрэн хамруулах, тооллогын хуудасны асуултад үнэн зөв хариулах талаар улс төрийн сонсгал, лекц, бригад, хэсгийн өдөрлөг, аман ухуулгаар өргөн сурталчлах;

в) бүх шатны сургууль курст суралцаагчдад тооллогын талаар лекц, яриа хийх;

г) тооллогын ухуулах, зурагт хуудас, санамжийг үйлдвэр, албан газар, сургууль, сёёл урлаг (сöёлын ордон, кино театр, клуб, улаан булан, номын сан) худалдаа, үйлчилгээ, олон нийтийн газарт гаргана.

**36.** Хөдөө аж хуйн нэглийн өрхийн бүртгэл, ажилчин, албан хаагч, бусад иргэдийн гэр бүлийн бүртгэл, хүн ам, хөдөлмөрийн нөөцийн анхан шатны бүртгэлийн хётлэлт, регистрийн дугаар олголтод хамрагдсан байдал, иргэний баримт бичигт үзлэг шалгалт хийж, илэрсэн зөрчил бүрийг арилгаж, регистрийн дугаар аваагүй хүмүүст регистрийн дугаарыг нөхж олгосон байна.

Байнга оршин суугаа газраа тооллогод хамрагдахгүй хүмүүс (авто тээврийн жолооч, отор нүүдэл хийгчид гэх мэт)-ийг иргэний үндсэн (паспорт, төрслийн гэрчилгээ, хувийн үнэмлэх) баримт бичгээ биедээ авч явах ажлыг зохион байгуулна. Өрх, хүн амын шилжих хөдөлгөөн, засаг захиргааны харьяалалтай холбоотой асуудлыг тооллогын ёмне бүрэн шийдвэрлэсэн байна.

**37.** АДХ-ын гүйцэтгэх захиргаад хүн амын тооллогын тоологч нарыг хөдөөд 30—40 өрхөд, хотод 400—500 хүнд нэг тоологч байхлар бодож томилон 1988 оны 12 дугаар сарын 20-ноос эхлэн үндсэн ажлаас нь чөлөөлж (цулинг үндсэн байгууллагаас нь олгоно) тооллого явуулж, урьдчилсан дүнг гаргаж дуустал ажиллуулна.

**38.** Нэг тоологчид ногдох өрх, хүн амын тоог баримтлан, өөрийн нутаг дэвсгэрийн хэмжээнд тооллогын хэсгийг байгуулан хил хязгаарыг тогтоож, тооллогын хэсэг

бүрийн хариуцах газар нутаг, өрх, хүн амын тоог тусгасан схем, зураглалыг гаргаж бэлтгэсэн байна.

**39.** Хот, суурин газрын гудамж, талбай, орон сууц, байшин, хашааны нэр хаяг, дугаарыг шалган тодорхой болгож журамлуулах ажлыг хийнэ.

**40.** Ажлын хариуудлага сахилга, дадлага туршлага, бичиг үсгийн чадвар, тооллогын ажилд оролцох боломж, нөхцөлийг нь сайтар судлах үндсэн дээр тоологчоор ажиллах хүмүүсийг сонгон авч, аймаг, хотын тооллогын комисстай тохирон сум, хороо, район, орон нутгийн хотын тооллогын комисс албан ёсоор батлан тэдгээрийн анкетыг маягт ХАТ-8-ын дагуу бүрдүүлнэ. Нөөц бөгөөд хяналтын тооллогчийг 5—7 тоологч тутам нэг байхаар бодож мөн дээрх бүрэлдэхүүнд оруулан томилсон байна.

**41.** Тоологч наарт өөрийнх нь хариуцан тоолох хэсгийн схем, зураглалыг гарган өгч, түүнийг газар дээр нь тодорхой зааж үзүүлсэн байна.

**42.** Тоологчоор болон тооллогын ажилд оролцохоор батлагдсан бусад хүмүүсийн ажил, ээлжийн амралтыг үндсэн албан байгууллагатай нь урьдчилан тохиролцож зохицуулсан байна.

**43.** Харьяалсан нутаг дэвсгэртээ байгаа оюутан, сургачдын дотуур байр, зочид болон зорчигчдын тээврийн буудал, тэтгэвэр, асрамжийн газар, амралт, сувилал, эмнэлгийн захиргаадын зүгээс тооллого явуулахад тэдгээрийн гүйцэтгэх үүрэг, туслаалцаа дэмжлэгийн асуудлыг урьдчилан тохиролцсон байна. Шаардлагатай гэж үзвэл тэдгээр байгууллагын дэргэд тооллогын тусгай хэсэг байгуулан ажиллуулж болно.

**44.** Тооллогын маягт урьдчилсан дүнгийн хүснэгт, зааврын хангамж, хүрэлцээг нарийн тоодож, тооллогын хэсэг, тоологч нарыг тооллогын хуудас, маягт, заавраар хангасан байна. Тооллогод хамрагдах хүнийх нь тоогоор (зохих нөөцтэйгээр) тооллогын хуудсыг тоологч наарт хүлээлгэн өгнө.

**45.** Тоологч наарт тусгай программын дагуу семинар өгч тооллого явуулах зааврыг нарийн судлуулан тооллогын хуудас нөхөх дадлага эзэмшигүүлэн, шалгалт авч бэлтгэсэн байна.

**46.** Тоологч нараар хариуцсан хэсгийн нь айл өрх нэг бүрийн өрхийн хуудас (маягт ХАТ-2)-ыг бөглүүлэх ажлыг 1988 оны 12 дугаар сарын 21—30-нд багтаан хийлгэсэн байна.

47. Хөдөлмөрийн насын хөдөлмөрийн чадвартай хүн амаас нийгмийн зохион байгуулалттай хөдөлмөр эрхлээгүй байгаа хүний судалгаа болон эмэгтэйчүүдийн судалгааг 1988 оны 12 дугаар сарын 21—30-нд явуулж дуусгах ажлыг зохион байгуулна.

48. Тооллого явуулах, дүнг гаргах үед ажиллах контор, байр, хэрэглэх телефон, унааг холбогдох байгууллагуудтай урьдчилан тохиролцож бэлтгэсэн байна.

49. Тооллогын бэлтгэл ажлын биелэлтийн явцыг батлагдсан асуулт, графикийн дагуу аймаг, хотын комисст тухай бүр мэдээлж байна.

50. Тооллогын эхний өдөр нийт тоологчид тооллогын ажилд эхлэн орсон эсэхийг заавал шалгана. Хэрэв тоологчдоос хэн нэг нь тооллогын ажлаа эхлээгүй байвал шалтгааныг шуурхай тодруулж, цаашид ажиллах боломжгүй онцгой тохиолдолд урьдчилан бэлтгэсэн нөөц тоологчдоос тэдгээрийн оронд томилон ажиллуулна.

51. Хот, суурин газруудад тооллого явагдсан эхний өдөр тодорхой цагт тоологчдыг цуглувалж, тооллогын хуудсыг нэхсэн байдлыг шалгаж, заавар зөвлөлгөө өгнө.

52. Тоологч нарын тооллогын ажлын явц, тооллогын хуудасны нэхэлтийг өдөр бүр шалган хянах, шаардагдах арга хэмжээ авна.

53. Тооллогыг хүн олонтой, хөдөлгөөн ихтэй (оюутан, сурагчдын дотуур байр, зочид буудал, амралт, сувилал, асрамжийн газар зэрэг) газраас эхлэн явуулж, тооллогын явцад эдгээр газруудад шинээр ирсэн хүмүүсийг тооллогод хамруулах ажлыг зохион байгуулна.

54. 1989 оны 1 дүгээр сарын 10—11-ний өдрүүдэд тоологч, нөөц болон хяналтын тоологч нарын хүчээр хэсэг бүрт тоологдсон 16-аас дээш насын хүн амын 10-аас доошгүй хувьд нь шалгалтын тооллого явуулна. Энэ явцад тооллогод хамрагдаагүй хүн гарвал шалгалтын хуудастай хамт тооллогын хуудсыг шинээр нэхж, шалгалтын хуудсандаа тооллогын хуудсыг нэхсэн тухай зурж тэмдэглэнэ. (Шалгалтад хамрагдсан хүн бүрт шалгалтын хуудас маягт ХАТ-Зыг нэхнэ)

55. Шалгалтын хуудсыг тоологчийн нэхсэн тооллогын хуудастай заавал тулган шалгаж, тооллогын хуудсыг алдаатай нэхсэн байвал засуулна.

56. Шалгалтын тооллогоор тооллогод хамрагдсан боловч гэрчилгээгүй хүмүүс илрвэл «гэрчилгээ» олгоно.

57. Хэрэв өөр газраас яваа «гэрчилгээ»-гүй хүмүүст тооллогын «шалгалтын хуудас» нээсэн бол тооллогын комисс, уг хүний үндсэн захиргаанаас нь аймаг, хотын тооллогын комиссоор дамжуулан тооллогод хамрагдсан эсэхийг магадлаж, хамрагдаагүй бол тооллогод нэхж хамруулна.

58. Тооллогын шалгалтын хуудас нь тооллогын хэсэг бүрт дэс дараалсан дугаартай байна.

59. Тооллого явуулсан дараа тоологч бүрээс хүлээлгэн өгсөн тооллогын хуудсыг (нэхөгдсөн ба нэхөгдөөгүй) нэг бүрчлэн тоолж 1 дүгээр сарын 12—15-ны өдрүүдэд багтаан хүлээн авна. (Тооллогын хуудасны нэхэлтийн үнэн зөвийг шалгахад анхаарах зүйлийг 1 дүгээр хавсралтаас үз)

Тэгэхдээ нэхөгдсөн хуудас бүрийн асуултын хариултыг тоологчдоос зохих зааврын дагуу бөглөсөн байдал, хариултуудын уялдаа холбоо, үнэн зөвийг шалгана. Буруу нехсөн, их засвартай, урж, үнгэж гэмтээсэн хуудсыг шинэ хуудсан дээр хуулуулна.

60. Тоологч нараас тоологдсон өрхийн тоотой тэнцүү өрхийн хуудас (маягт ХАТ-2)-ыг хүлээж авна. Тэгэхдээ тоологчдоос зохих зааврын дагуу хуудсыг бөглөсөн байдал, түүний асуулт хариултын уялдаа холбоо, үнэн зөвийг шалгаж хүлээж авна. (Өрхийн хуудасны нэхэлтийн үнэн зөвийг шалгахад анхаарах зүйлийг 2 дугаар хавсралтаас үз).

61. Хөдөлмөрийн насын хөдөлмөрийн чадвартай хүн амаас нийгмийн зохион байгуулалттай хөдөлмөр эрхлээгүй байгаа хүний судалгаа болон эмэгтэйчүүдийн судалгааны хуудсыг хүлээж авна.

62. Тооллогын холбогдолтой бүхий л материалыг нууц, бүрэн бүтэн байдлыг нь хангахайц зориулалтын төмөр шүүгээ (сейф)-нд хадгална.

63. Тооллогод оролцсон ажилтнуудын ажилд үнэлэлт, дүгнэлт өгнө.

64. Тооллогын урьдчилсан дунг зохих маягт, зааврын дагуу З хувь гаргана.

65. Тооллогын материалыг (тооллогын бүх хуудас, өрхийн хуудас, 2 судалгааны хуудас, холбогдох хүснэгтээр гаргасан 2 хувь урьдчилсан дунгүүд) илтгэх хуудасны хамт тооллогын комиссын дарга, гишүүдээс томилогдсон төлөөлөгчид, аймаг, хотын тооллогын орон тооны бус түр төвчоонд нэгдүгээр сарын 16—20-нд хүлээлгэн өгнө.

## **ГУРАВ. Тооллогын түр товчооны ажлын заавар, гүйцэтгэх үүрэг**

66. Аймаг, хотын тооллогын комиссын удирдлагаар тооллогын бэлтгэл ажлыг хангуулна.

67. Тооллого, судалгаануудын маягт, заавар, урьдчилсан дүнг гаргах хүснэгтийн хүрэлцээ хангамжид судалгаа хийж, шаардлагатай тохиолдолд нөхөн хангах ажлыг орон нутагт зохион байгуулна.

68. Төвөөс баталсан тооллогын комисс, хэсгийн дугаарыг сум, хороо, район, орон нутгийн хотын тооллогын комиссуудад хүргүүлнэ.

69. Сум, хороо, район, орон нутгийн хотын комиссоос тооллогын хэсгийн схем, эураглал, гаргаж, тоологч нарыг зохих нормын дагуу томилсон эсэхэд хяналт тавина.

70. Хот, суурин газрын гудамж, талбай, орон сууцны байшин, хашааны нэр хаяг, дугаарыг сум, хороо, район, орон нутгийн, хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас тодорхой болгож, журамлах ажилд хяналт тавина.

71. Тооллогын материалыг сум, хороо, район, орон нутгийн хотын тооллогын комиссоос 1 дүгээр сарын 16—20-ны өдрүүдэд тусгай хуваариар хүлээн авах ажлыг зохион байгуулна.

72. Сум, хороо, район, орон нутгийн хотын тооллогын комисс бүрээс тооллогын хуудас (нөхөгдсөн ба нөхөгдөөгүй)-ыг зориулалтын хавтасны хамт нэг бүрчлэн тоолж хүлээж авна.

Тэгэхдээ нөхөгдсөн хуудас бүрийн асуултын хариултыг тоологчдоос зохих зааврын дагуу бөглөсөн байдал, хариултуудын уялдаа холбоо, үнэн зөвийг шалгана. (тооллогын хуудасны нөхөлтийн үнэн зөвийг шалгахад анхаарах зүйлийг 1 дүгээр хавсралтаас үз).

73. Сум, хороо, район, орон нутгийн хотын комиссоос тоологчдос өрхийн тоотой тэнцүү орхийн хуудас, эмэгтэйчүүдийн болон, хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай хүн амаас нийгмийн зохион байгуулалттай хөдөлмөр эрхлээгүй байгаа хүний судалгааны хуудсыг хүлээж авна. (өрхийн хуудасны нөхөлтийн үнэн зөвийг шалгахад анхаарах зүйлийг 2 дугаар хавсралтаас үз).

74. Хүн ам, орон сууцны тооллогын урьдчилсан дүнг аймгийн хэмжээгээр 2 хувь нэгтгэнэ. Үүнд:

а) хүн амын тоо, насаар (бүгд, хот, хөдөө)-маягт УД-1;  
12

- б) хүн амын нийгмийн бүлэг, боловсрол, харьяаллын байдал, өрхийн тоо-маягт УД-2;
- в) хүн амын ажил эрхлэлт-маягт УД-3;
- г) сум, хорооны хүн амын тоо-маягт УД-4;
- д) амины байшин, гэр, зуслангийн байшигийн тоо-маягт СУД-1.

75. Тооллого, судалгааны материал, аймгийн хүн ам, орон сууцны фондын тооллогын урьдчилсан дүнг батлагдсан маягт, зааврын дагуу тус бүр 1 хувь, сум, хороо, район, орон нутгийн хотуудаас гаргасан урьдчилсан дүнгийн хувийг илтгэх хуудасны хамт аймгийн тооллогын комисс, түр товчоонос томилогдсон төлөөлөгчид БНМАУ-ын Төлөвлөгөө, эдийн засгийн улсын хороонд 1 дүгээр сарын 26-наас 2 дугаар сарын 5-ны хооронд тусгай хуваариар хүлээлгэн өгнө.

## **ДӨРӨВ. Тоологч нарын ажлын заавар**

76. Тоологч нар батлагдсан зураглал, схемийн дагуу хүн амыг тооллогод бүрэн хамруулж, тооллогын хуудасны асуултад үнэн зөв хариулт авч, тооллогыг графикт хугацаанд нь чанартай явуулах үүрэгтэй.

77. Тоологчид нь тооллого явуулах маягт, зааврыг сайтар судалж, зааврыг хатуу баримтлан ажиллана.

78. Тоологчид сум, хороо, район, орон нутгийн хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас олгосон хүн ам, орон сууцны 1989 оны тооллогын тоологчийн үнэмлэхтэй байх бөгөөд үнэмлэхээ үргэлж биедээ авч явна.

79. Тоологч бүр 12 дугаар сарын 21—30-нд өөрийн хариуцсан хэсэгт байршилалын зураглал, схемийн дагуу орон сууцны байшин, гэр (өрх) нэг бүрээр орж, хүн амыг тооллогод бэлтгүүлэхийн зэрэгцээ дараах үндсэн ажлыг хийсэн байна. Үүнд:

а) өрхийн хуудас (маягт ХАТ-2)-ыг сууц, зуслангийн байшин, гэрийн холбогдолтой үзүүлэлтийн хамт үнэн зөв, бүрэн бөглөсөн байна;

б) хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай хүн амаас нийгмийн зохион байгуулалттай хөдөлмөр эрхлээгүй байгаа хүний судалгаа (маягт ХАТ-4)-г хийнэ;

в) эмэгтэйчүүдийн судалгаа (маягт ХАТ-5)-г явуулна.

Тоологч нар нь эмэгтэйчүүдийн судалгаа явуулж байгаа нийгэм, хүн ам зүйн ач холбогдлыг судалгаанд хам-

рагдагсад зөв ойлгуулах, судалгааны заавартай урьдчилан танилцуулах ажлыг хийж, хуудсыг тэднээр өөрсдөөр нь бэглүүлнэ;

г) тооллогын үед түр суугаа, түр эзгүй, ажил үйлдвэрлэлийн онцлогоос шалтгаалан гэр орондоо байхгүй байх хүмүүсийн судалгааг нарийвчлан гаргаж, тэднийг хэдийд тооллогод хамрагдах боломжтой цаг хугацааг урьдчилан тогтоосон байна.

80. Хүн амд тооллогын ач холбогдлыг сурталчилж, тооллого явуулах хугацааг тэдэнд урьдчилан мэдэгдэж, тооллогын хуудасны асуултад хариу өгөхөд бэлтгүүлнэ.

81. Тооллогын хуудсанд бичигдсэн хариулт нь хувь хүний нууцтай холбоотой тул тоологчдоос хариултын агуулгыг бусдад задруулах, нэхсөн хуудсыг алдаж үрэгдүүлэхийг хатуу хориглоно.

82. Тоологч бүр тооллогын хуудас, бусад маягтыг тооллогын комиссоос нарийн тоолон хүлээн авч, тооллогын эцэст тоо ширхэгээр нь буцааж тооцоо хийж тушаана.

83. Тооллого, судалгааны хуудсуудыг нугалах, үнгэх, урах, тастахыг хатуу хориглоно.

Хуудаснуудын асуултын хэд хэдэн хариултыг буруу бичсэнээс засаж балласан, ойлгомжгүй болгосон, бохирдуулсан бол шинэ хуудсанд дахин хуулна

84. Зориулалтын маягт, хавтсыг цэвэр нямбай, гэмтээхгүй хэрэглэж, заавраар зөвшөөрснөөс бусад үг, үсэг бичихийг хориглоно.

85. Тухайн хэсэгт тоологдооюур өрхийн хуудас (ХАТ-2)-аар бүртгэгдсэн хүмүүсээс зайлшгүй шаардлагаар тооллогын хугацаанд гадагш явах болбол урьдчилан тоолж «гэрчилгээ» олгож болно.

86. Хүн ам, орон сууцны тооллогыг 1989 оны 1 дүгээр сарын 5-ны өглөөний 8 (орон нутгийн) цагаас олон хүнтэй, хөдөлгөөн ихтийг газраас эхлэн явуулна.

87. Тоологчид өөрийн хэсэгт тоологдсон 7-оос дээш насны нийт хүмүүст «гэрчилгээ» олгоно. Энэ гэрчилгээг 1989 оны 1 дүгээр сарын 16-ныг дуустал биедээ авч явагыг хүн бүрт анхааруулна.

88. Тоологч нар батлагдсан зураглал, схемийн дагуу хэсгийнхээ хүн амыг тооллогод бүрэн хамруулж, тооллогыг графикт хугацаанд чанартай дуусгахад санаачилгатай ажиллана.

89. Тооллогын комисстий хамтран тоологч нар өөрийн

хариуцсан хэсэгт тоологдсон 16-аас дээш насны хүн амын 10-аас доошгүй хувьд шалгалтын тооллогыг хийнэ. Шалгалтад хамрагдсан хүн бүрт шалгалтын хуудас (маягт ХАТ-3)-ыг нехне. Энэ явцад тооллогод хамрагдаагүй хүн гарвал шалгалтын хуудастай хамт тооллогын хуудсыг шинээр нехж, шалгалтын хуудсандaa тооллогын хуудсыг нэхсөн тухай зурж тэмдэглэнэ.

90. Тооллогч бүр тооллогын хуудас, маягтуудаа зөв нэхсөн эсэхийг өөрсдөө нэг бүрчлэн сайтар шалгаж, тооллогын хуудсыг өрх, хүн бүрээр дэс дугаарлан 1989 оны 1 дүгээр сарын 12—15-нд харьялагдах тооллогын комисстoo хүлээлгэн өгнө.

91. Тооллогын хуудас маягтын тооцоог тооллогын комисстий хийж, ажлаа дүгнүүлнэ.

## ТАВ. Тооллогын хуудас нэхөх заавар

92. Тооллогын хуудас нь хүн амын тооллогын үр дүнг нэгтгэн боловсруулахад ашиглагддаг үндсэн баримт материалы болох тул тоологч бүр тооллогын хуудсыг заавар, аргачлалын дагуу үнэн зөв, цэвэр нямбай нэхсөн байна.

93. Тооллогын хуудсыг зөвхөн цэнхэр, хөх өнгийн чернилээр нэхне. Улаан, ногоон, хар өнгийн черниль, тосон бал, хаарандаагаар нэхөхийг хориглоно.

94. Тооллогын хуудасны хөдөөгийн хаягийн байршил заасан хэсэг, 1-3, 9-12, 14 дүгээр асуултад хариулахдаа хойно нь бичигдсэн хариултаас аль тохирохыг олж түүнийг арын тооны хамт доогуур нь зурж тэмдэглэнэ. Харин 4-8, 13, 15 дугаар асуултын хариулт нь тоо буюу үгээр бичигдсэн байна.

95. **Тооллогын хуудасны №.** Тоологч бүр тооллогод хамруулж тоолсон хүн бүрийн тооллогын хуудсанд дэс дараалан дугаар өгнө. Тооллогын хуудасны эцсийн дугаар, тооллогод хамрагдсан нийт хүний тоотой тэнцүү байна.

96. **Тооллогын комиссийн болон хэсгийн №** гэсэн үзүүлэлтэд Төлөвлөгөө, эдийн засгийн улсын хорооноос тухайн тооллогын комисс, хэсэгт олгосон тусгай № бичнэ. Тооллогын хуудас бүрт энэ № бичих бөгөөд буруу ташаа бичиж, орхигдуулж болохгүй.

97. **Аймаг (хот)** гэсэн үгийн дээрх шугам дээр тухайн аймаг, хотын нэрийг бичнэ. ЖИШЭЭ нь: Ховд, Дорнод, Өмнөговь, Улаанбаатар, Эрдэнэт гэх мэт. Код бичих

зориулалтын зайд тухайн аймаг (хот)-т олгосон код (үсэг)-ыг энэ зааврын 3 дугаар хавсралтаас харж маш цэвэрхэн, гаргацтай дармалдаж бичнэ.

**98. Овог нэр.** Тухайн хүний овог нэрийг товчлохгүй-гээр бүрэн гүйцэт бичнэ. Хүний овгийн төгсгэлд «ийн», «ын» дагавар залгахгүй. **ЖИШЭЭ** нь: Дорж овогтой Батыг Доржийн Бат гэж бичихгүй. Овог «Дорж», нэр «Бат» гэж бичнэ.

Хүний нэрийг сонсголоороо буруу бичиж болохгүй. Хүний овог, нэр нь иргэний паспорт, төрсний гэрчилгээнд бичсэнтэй тохирч байх шаардлагатай.

**99. РД (регистрийн дугаар).** Тухайн хүний төрсний гэрчилгээ, иргэний паспорт (цэргийн албан хаагчийн хувьд хувийн үнэмлэх)-аас регистрийн дугаарыг авч үнэн зөв алдаагүй хуулж бичнэ.

Гадаадад байгаа иргэд, Батлан хамгаалах яам, Нийгмийг аюулаас хамгаалах яамны харьяа байгууллагад ажиллаж байгаа зарим хүмүүс болон регистрийн дугаарыг нь хуулж бичих иргэний баримт бичиг нь өөрт нь байхгүй хүмүүсээс регистрийн дугаар олгогдсон эсэхийг асууж, регистрийн дугаар бичих зайд дугаар авсан бол «дугаартай», дугаар аваагүй бол «дугааргүй» гэж бичнэ. Регистрийн дугаар бичих зориулалтын зайд «дугааргүй» гэж бичихийн зэрэгцээ түүний дор байгаа код бичих нүхэнд «1» гэж заавал бичнэ.

**ТАЙЛБАР:** Регистрийн дугаар нь 2 үсэг, 8 цифрээс бүрдэнэ.

Регистрийн дугаарын эхний 2 үсэг нь уг дугаарыг олгосон аймаг (хот), сум (хороо, район)-ыг, дараагийн 6 цифр нь тэр хүний төрсөн он, сар, өдрийг, 7 дахь цифр нь эрэгтэй, эмэгтэйг (давхар утгаараа мөн өдөр төрсөн тус сум, хороо, районд байнга оршин суудаг хүмүүсээс хэддүгээрт нь регистрийн дугаар авсныг) тус тус заана. 8 дахь цифрийг (сүүлчийн цифр) регистрийн дугаарыг буруу бичихээс хамгаалж тусгай алгоритмаар бодож олж тавина. **ЖИШЭЭ** нь: Даржаа овогтой Баатар, 1942 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр төрсөн, эрэгтэй, Өмнөговь аймгийн Ноён суманд мөн өдөр төрсөн тэр суманд регистрийн дугаар олгох үед байнга амьдарч байсан эрэгтэйчүүдээс хоёрдугаарт; Даваа овогтой Алтанцэцэг 1959 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр төрсөн, эмэгтэй, Өмнөговь аймгийн Да-

ланзадгад хотод мөн өдөр төрсөн тэр хотод регистрийн дугаар олгох үед байнга амьдарч байсан, эмэгтэйчүүдээс нэгдүгээрт тус тус регистрийн дугаар авсан гэвэл:

Баатарын регистрийн дугаар:

K	3	4	2	0	9	1	7	3	5
---	---	---	---	---	---	---	---	---	---

Алтанцэцэгийн регистрийн дугаар:

K	1	0	5	9	1	1	0	3	0	9
---	---	---	---	---	---	---	---	---	---	---

байх юм.

**100. Өрхийн №.** Тоологч бүр тооллогод хамрагдсан өрх бүрт дэс дараалан дугаар олгож бичнэ. Өрхийн дугаар нь өрхийн бүх гишүүдэд ижил байна. **ЖИШЭЭ** нь: Дорж овогтой Бат, эхнэр Дулмаа, хүү Сэргэлэн нарын хамт гурван ам бүлтэй бол Батын өрхийн № 49 байвал эхнэр Дулмаа, хүү Сэргэлэн нарын тооллогын хуудсанд өрхийн № мөн 49 гэж бөглөгднө. «Ганц бие», «гэр бүлээсээ тусдаа» байгаа хүмүүсийн тооллогын хуудасны өрхийн № нь уг хүний тоологдсон өрхийн дугаартай ижил байна.

**101. Хот, хот маягийн суурингиийн нэр.** Тухайн хүний сууж байгаа хот, маягийн суурингиийн албан ёсны нэрийг бичнэ. (Хот, хот маягийн суурингиийн жагсаалтыг хавсралт № 4-өөс үзнэ үү). Код бичих зориулалтын зайд тухайн хот, хот маягийн сууриннд олгосон код (үсэг)-ыг энэ зааврын 4 дүгээр хавсралтаас харж маш цэвэрхэн, гаргацтай, дармалдаж бичнэ.

**102. Район (хорооны) нэр.** Улаанбаатар хотод районы нэр, бусад хотод хорооны нэрийг бичнэ. Код бичих зориулалтын зайд Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотын тухайн район, хороонд олгосон код (үсэг)-ыг энэ зааврын 3 дугаар хавсралтаас харж маш цэвэрхэн, гаргацтай дармалдаж бичнэ.

**103. ОСГ-ны ...дугаар хороо.** Энэ асуултыг Улаанбаатар хот болон ОСГ-ны хороотой бусад хотод нехнэ.

**104. Гудамжны нэр.** АДХ-ын гүйцэтгэх захирагаанаас олгосон албан ёсны нэрээр бичнэ. **ЖИШЭЭ** нь: «Энхтайван», «Алтайн-1», «Уурхайчин-2» гэх мэт.

**105. Байшин №, суудны №, хашааны №.** Тухайн хүний оршин суугаа байшин, сууц, хашааны дугаарыг бичнэ.

**106. Сум, хорооны нэр.** БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчийн зарлигаар батлагдсан нэрийг товчлохгүйгээр бүрэн гүйцэт бичнэ. Тухайн иргэн чухам хаана сууж байгаагий нь байршлын хувьд зөв тодорхойлохын тулд сум (хороо)-ын төвд-1, бригад, хэсэг, фермийн төвд-2, хөдөөд-3 гэсэн хариултын аль тохирохыг арын тооны хамт доогуур нь зурсан байна. Код бичих зориулалтын зайд тухайн сум (хороо)-д олгосон код (үсэг)-ыг энэ зааврын З дугаар хавсралтаас харж маш цэвэрхэн, гаргацтай дармалдаж бичнэ.

#### **НЭГДҮГЭЭР АСУУЛТ. Өрхийн тэргүүлэгчтэй ямар хамааралтай болох**

**107. Өрхийн тэргүүлэгч нь байнга оршин суугч гишүүдийн дотроос 16, түүнээс дээш насын хүмүүсийн хэн нэг нь байх бөгөөд өөрсдөө шийдэж хариулна. Хэрэв өрхийн гишүүд хэнийгээ өрхийн тэргүүлэгч болгохоо шийдэж чадахгүй бол өрхийн мөнгөн орлогын ихэнхийг олдог хүнийг өрхийн тэргүүлэгчээр тооцно. Харин өрхийн бусад гишүүдийн хувьд нэгдүгээр асуултын хариултаас аль тохирохыг нь олж доогуур нь зурна. Тухайн өрхөд «Ганц бие», «Гэр бүлээсээ тусдаа» байгаа хүмүүс байвал гишүүдийн адил тооллогод хамруулна.**

**Ганц бие.** Гэр бүлгүй, тэрчлэн гэр бүлтэй боловч өрхөөсөө байнга тусдаа амьдардаг, санхүү, материалын талаар ямар нэгэн холбоогүй, хүмүүсийг «Ганц бие хүн» гэж нөхнэ.

**Гэр бүлээсээ тусдаа.** Өрхөөсөө байнга тусдаа амьдардаг боловч байнгын материалын холбоотой хүмүүс, тэрчлэн өрхөөсөө тусдаа түр суугаа хүмүүсийг «Гэр бүлээсээ тусдаа» гэж нөхнэ.

#### **ХОӨРДУГААР АСУУЛТ**

**108. Тооллогод хамрагдсан хүний тооллогын хуудсанд «Байнга суудаг, түр эзгүй, түр суугаа» гэсэн гурван үзүүлэлтийн аль тохирохыг зурж тэмдэглэсэн байна.**

**109. Байнга суудаг.** Тухайн засаг захиргааны нутаг дэвсгэрт байнга оршин суудаг, тооллогын үед үндсэн захиргаандаа бэлэн тоолуулсан хүмүүсийн хувьд «Байнга

суудаг» гэсэн үзүүлэлтийн доогуур зурна. Үүнээс гадна дараах хүмүүс «Байнга суудаг»-т тооцогдоно. Үүнд:

- а) шөнийн ээлжинд ажиллаж байгаа хүмүүс;
- б) харуул, манаа, жижүүр хийгчид;
- в) албан ажил, үүргээ хэд хэдэн хоногоор үргэлжлүүлэн гүйцэтгэдэг (төмөр замчид, агаарын болон авто тээвэрчид, тэдгээрийг дагалдан ажиллагчид, шуудан хүргэч гэх мэт) хүмүүс;
- г) шөнийн сувилалд явагчид, 1—2 хоногийн хугацаагаар амралтад явсан хүмүүс, 24 цагийн ясли, цэцэрлэгт явдаг хүүхдүүд;
- д) замд буюу хээр явваа (түлээ, ан гөрөөнд явагч, мал хайж явсан гэх мэт) хүмүүс.

**110. Түр эзгүй.** Өөрийн үндсэн засаг, захиргааны нутаг дэвсгэрээс гадагш явсан (6 сараас илүүгүй хугацаагаар) тооллогын үед байхгүй байгаа хүмүүсийг «Түр эзгүй» гэж үзнэ.

Түр эзгүй хүмүүст дараах шалтгаанаар явагчдыг оруулна. Үүнд:

- а) албан томилтоор явваа хүмүүс;
- б) түр хугацаагаар буюу улирлын ажлаар гадагш явсан хүмүүс;
- в) амралт, сувилал, аялал жуулчлааар явсан хүмүүс;
- г) үйлдвэрлэлийн дадлага, курс хийж байгаа хүмүүс;
- д) эмнэлэгт хэвтэж эмчлүүлэгчид (6 сараас илүүгүй хугацаагаар);
- е) төрөх газар байгаа хүүхэд, эхчүүд;
- ж) садан төрөл, найз нөхөдрүүгээ айлчлахаар явсан хүмүүс;
- з) ойн сувиллын сургуульд очиж суралцаж буй хүүхдүүд;
- и) цэргийн цугларалт, хээрийн сургуульд явваа хүмүүс;
- к) урьдчилан мөрдөн байцаалтад хоригдож байгаа хүмүүс;
- л) жижиг танхайн хэргээр 30 хүртэл хоногийн хугацаагаар баривчлагдсан зэрэг хүмүүс орно.

**111. Түр суугаа.** Өөрийн үндсэн засаг захиргаанд биш өөр засаг захиргааны нутаг дэвсгэрт 6 сараас доош хугацаагаар түр сууж байгаа хүмүүсийг «Түр суугаа» гэж тоолно. Өөрөөр хэлбэл «Түр эзгүй» гэж үндсэн захиргаандаа бүртгэгдсэн хүмүүс (110 дүгээр зүйлд) тооллогын үед байгаа газартаа «Түр суугаа»-гаар тоолгодоно. Үүнээс гад-

на нисэх онгоц, галт тэрэг, авто тээврийн буудалд байрлах байгаа хүмүүсийг тооллогын «гэрчилгээ»-гүй бол тухайн хэсэгт «Түр суугаагаар» тоолно.

**112. Түр суугаа хүмүүсийн байнга суудаг хаяг.** Түр суугаа гэж тооллогын хуудас нөхсөн бүх хүний байнга амьдардаг аймаг, хот, сум, хороо, районы нэрийг бичнэ.

### ГУРАВДУГААР АСУУЛТ

**113. Эрэгтэй, эмэгтэй.** Зоих хариултын доогуур зурна.

**ДӨРӨВДҮГЭЭР АСУУЛТ.** Төрсөн, он, сар, өдөр, аймаг, хот, сум (хороо)

**114.** Тухайн хүний төрсөн он, сар, өдрийг регистрийн дугаарт бичигдсэнээр нь бичнэ. (ЖИШЭЭ №: 1940—2—25). Харин насыг заавал бүрэн насалсан жилээр нь авна. Бүтэн нас хүрэхэд хэдэн хоног дутуу байлаа ч насыг дэвшишүүлж болохгүй. ЖИШЭЭ №: бүтэн 12 нас 11 сар 25 хоногтой байхад 13 настай гэж авахгүй, 12 нас гэж бүртгэнэ. Нэг хүртэлх наслын хүүхдийн насыг 0 гэж бичнэ.

**115. Хүмүүсийн насыг дараах аргаар тодорхойлж бичнэ.** Он бүрийн 1 дүгээр сарын 5-ны өдрийн өмнө төрсөн хүмүүсийн хувьд 1989 оноос төрсөн оныг хасахад уул хүмүүсийн наслсан бүтэн жил гарна. ЖИШЭЭ №: Балдан 1939 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр төрсөн байвал 50 (1989—1939) настай болно. Харин 1 дүгээр сарын 5-наас хойш төрсөн оныг хасч, ялгавраас нь 1-ийг хасч насыг тодорхойлно. ЖИШЭЭ №: Даши, 1943 оны 1 дүгээр сарын 10-нд төрсөн бол түүнийг насыг 45 (1989—1943—1) гэж бичнэ. Төрсөн оноор нас тодорхойлох хүснэгтийг хавсралт № 5-ас үзэж ашиглана уу).

**116.** Өндөр настангууд, өөрсдийн насыг тодорхой мэдэхгүй, хуучин тооллоор төрсөн жилийнхээ нэрийг мэдэж байгаа тохиолдолд тоологчид хүснэгт 1-ийг ашиглаж насыг тодорхойлно.

**117. Тухайн хүний төрсөн аймаг (хот), сум (хороо)-ын нэрийг товчлохгүйгээр (одоогийн нэрээр) бүрэн гүйцэд бичнэ. ЖИШЭЭ №: «УБ хот» гэж бичихгүй «Улаанбаатар» гэж бичнэ. Код бичих зориулалтын зайд тухайн аймаг (хот), сум (район, хороо)-д олгосон код (үсэг)-ыг энэ зааврын 3 дугаар хавсралтаас харж маш цэвэрхэн, гарцаатай дармалдаж бичнэ.**

Жил	Нис									
	1	2	3	4	5	6	7	8	9	10
Хулгана	5	17	29	41	53	65	77	89	101	113
Үхэр	4	16	28	40	52	64	76	88	100	112
Бар	3	15	27	39	51	63	75	87	99	111
Туулай	2	14	26	38	50	62	74	86	98	100
Луу	1	13	25	37	49	61	73	85	97	109
Могой	12	24	36	48	60	72	84	96	108	
Морь	11	23	35	47	59	71	83	95	107	
Хонь	10	22	34	46	58	70	82	94	106	
Мич	9	21	33	45	57	69	81	93	105	
Тахна	8	20	32	44	56	68	80	92	104	
Нохой	7	19	31	43	55	67	79	91	103	
Гахай	6	18	30	42	54	66	78	90	102	

### ТАВДУГААР АСУУЛТ. Яс үндэс

**118.** Тухайн хүний хариулснаар яс үндсийг бичнэ. Хүүхдийн яс үндсийг эцэг, эх нь тодорхойлно. Хэрэв эцэг, эх нь тодорхойлж чадахгүй нөхцөлд хүүхдийн яс үндсийг эхийнхээр нь бөглөнө.

### ЗУРГАДУГААР АСУУЛТ. Аль улсын харьяат

**119.** Энэ асуултын хариултыг хүмүүсийн хариулснаар нь бичнэ. БНМАУ-ын харьяат бүх иргэдэд «Монгол» гэж бичнэ. Харин бусад улсын харьяат нарыг ЭХУ, Болгар, Куба, Хятад гэх мэтээр хавсралт № 6-д бичсэний дагуу нөхцөн байна.

**120.** Эцэг, эх нь хоёр өөр улсын харьяат байвал хүүхдийн нь харьяаллыг эцэг, эхийн саналыг үндэслэж бичнэ. Хэрэв эцэг, эхийн санал зөрвөл байнга оршин суугаа улсын харьяат гэж бөглөнө.

**121. Аль ч улсын харьяалалгүй хүмүүсийг «Харьяалалгүй» гэж бичнэ.**

**122. Дагаар орж ирсэн, БНМАУ-ын харьяат болоогүй хүмүүсийг ямар улсаас орж ирсэн тэр улсын нэрийг нь бичиж ард нь «дагаар» гэж бичнэ.**

## ДОЛДУГААР АСУУЛТ. Ажилладаг байгууллага, суралцдаг сургууль

123. Тухайн хүний ажилладаг байгууллагын нэрийг үйлдвэрлэлийн төрөл, салбарыг тодорхойлж болохуйцаар, суралцдаг сургуулийг албан ёсны бүрэн нэрээр бичнэ. ЖИШЭЭ нь: «Шарын голын нүүрсний уурхай», «Авто тээврийн II бааз» гэж бичихээс «Шарын голын уурхай» «Авто тээврийн бааз» гэж бичиж болохгүй.

Харин тухайн байгууллагын нэрэмжит нэрийг бичихгүй, ЖИШЭЭ нь: «Д. Сүхбаатарын нэрэмжит Улсын хэвлэлийн комбинат» гэхгүй «Улсын хэвлэлийн комбинат» гэж бичнэ.

124. Үйлдвэрийн нэгдэл, комбинатын харьяа үйлдвэр, аж ахуйн газарт ажилладаг хүмүүсийн ажилладаг байгууллагыг нэгдэл, комбинатаар нь биш, нэгж үйлдвэрийн нэргээр бичнэ. ЖИШЭЭ нь: Ноосны үйлдвэрийн нэгдлийн харьяа Ноос угаах үйлдвэр, Оёдлын үйлдвэрийн нэгдлийн харьяа Хүүхдийн хувцасны үйлдвэрийг «Ноос угаах үйлдвэр», «Хүүхдийн хувцасны үйлдвэр» гэж бичнэ.

125. Нийтийн аж ахуй, ахуйн үйлчилгээний байгууллагад ажилладаг хүмүүст ажилладаг байгууллага гэсэн хүснэгтэд үйлдвэрлэл, ажил үйлчилгээний төрлийг нь зааж бичнэ. ЖИШЭЭ нь: «Гутал засварын газар», «Усчин», «Хувцас засварын газар», «Зочид буудал», «Орон сууцны трест» гэх мэт.

126. Хэрэв үйлдвэрийн газар нь сангийн аж ахуй, хөдөө аж ахуйн нэгдэл, хөдөө аж ахуйн нэгдэл дундын хоршооллын харьяа бол үйлдвэрлэлийн төрлийг өмчийн хэлбэрээр ялгаж болохоор бичнэ. ЖИШЭЭ нь: «Сангийн аж ахуйн талхны газар», «Нэгдлийн гуанз», «Нэгдэл дундын хоршооллын трактор засварын газар» гэх мэт.

127. Барилгын байгууллагуудад ажил эрхэлдэг хүмүүсийн ажилладаг байгууллагыг «барилгад» гэж ерөнхий нэргээр бичихгүй. «Хотын барилга трест», «Нэгдлийн барилга засварын бригад», «Усны аж ахуйн барилга контор» гэх мэтээр бичнэ.

128. Үйлдвэр, албан байгууллагад үйлчилж байгаа нийтийн хоолны байгууллагын харьяа гуанз, цайны газар болон эмнэлэг, ахуйн үйлчилгээний цэг салбарын нэрийг үйлчилж байгаа байгууллагаар нь биш харьяалж удирддаг салбар байгууллагын нэrtэй хамт бичнэ. Харин үйлдвэр,

22

албан байгууллагаа өөрийн харьяа гуанз, цайны газар, хүүхдийн ясли, цэцэрлэг зэрэг цэг салбартай бол уул цэг салбарт ажилладаг хүний ажилладаг байгууллагыг заавал үйлдвэр, албан байгууллагын нэrtэй нь хамт бичнэ. ЖИШЭЭ нь: Улсын барилгын хорооны ажилчин, албан хаагчдад үйлчилдэг 49 дүгээр гуанз, «Сүхбаатарын районы нийтийн хоолны трестийн 49 дүгээр гуанз» гэж, харин Улаанбаатар хотын Хивсний үйлдвэрийн гуанз нь уг үйлдвэрийнхээ харьяа тул «Улаанбаатар хотын Хивсний үйлдвэрийн гуанз» гэх мэтээр тус тус хариулна.

129. БНМАУ-ын нутаг дэвсгэр дээр ажиллаж буй Зөвлөлтийн байгууллагуудад ажиллагчдын ажилладаг байгууллагын нэрийн нь өмнө «Зөвлөлтийн» гэсэн тодотгол бичнэ. Мөн ЭХУ болон бусад улстай хамтарсан үйлдвэр, байгууллагын нэрийг бичихдээ түүний харьяа удирддаг дээд байгууллагын нэрийг бүрэн буюу товчилж бичнэ. ЖИШЭЭ нь: «Зөвлөлтийн барилгын III трест», «УБТЗ-ын Чойрын худалдааны V контор», «Монголсовцветмет нэгдэл», «Монголболгарметалл нэгдэл» гэх мэт.

130. Тооллогын үед хоёр байгууллагад хавсран ажиллаж байгаа хүмүүс, ажилладаг байгууллагаа аль байгууллага гэж үзнэ тэр байгууллагын нэрийг бичнэ. Гэхдээ цалин (орлого)-ийнхаа ихэнх хувийг авдаг, ажлын цагийн дийлэнх хувийг ажилладаг байгууллагаараа бичүүлэх нь зүйтэй.

131. Жирэмсний болон хүүхэд төрүүлсний дараах амралт, хүүхдээ асрал чөлөөтэй байгаа эмэгтэйчүүдийн ажилладаг байгууллагыг орон тоо нь хадгалагдаж байгаа байгууллагын нэргээр бичнэ.

132. Амины туслах аж ахуй эрхэлдэг нэгдэлчид, бусад иргэд, тэдгээрийн хөдөлмөрийн наасанд хүрсэн гэр бүлийн гишүүдийн ажилладаг байгууллагыг «Амины туслах аж ахуй» гэж бичнэ.

133. Хөдөлмөрийн нөхөрлөл (хоршоолол)-д ажиллаж байгаа хүмүүсийн ажилладаг байгууллагыг дараах байдаар бичнэ:

а) үйлдвэр, аж ахуйн газар, албан байгууллагад ажилладаг хүн ажлын бус цагаар хөдөлмөрийн нөхөрлөл (хоршоолол)-д ажилладаг (ЖИШЭЭ нь: Улаанбаатар хотод байдаг тээврийн нөхөрлөл) бол тэр хүний ажилладаг байгууллагыг үндсэн байгууллагаар бичнэ;

б) өндөр наасны болон хөдөлмөрийн нөхцөлөөр тэтгэвэрт гарсан, тахир дутуугийн групптэй боловч хөдөлмөр

23

рийн нөхөрлөл (хоршоолол)-д ажиллаж байгаа хүний ажилладаг байгууллагыг «хөдөлмөрийн нөхөрлөл (хоршоолол)»-д гэж бичнэ.

134. Ажиллахгүйгээр өндөр насын тэтгэвэр авагчдыг «өндөр насын тэтгэвэрт», хөдөлмөрийн чадвар алдсанаас тахир дутуугийн групптэй байгаа хүмүүсийн хувьд «I, II, III группд» хөдөлмөрийн нөхцөлөөр тэтгэвэрт гарагчид, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагчдыг «бусад тэтгэвэрт гэж тус тус бичнэ.

135. Улсын асрамжийн газарт асарч сувилуулагчдын ажилладаг байгууллагыг «улсын асрамжинд» гэж нөхнэ.

136. Тооллогын үед хөдөө аж ахуйн нэгдлийн гишүүд улсын байгууллагад ажиллаж байвал тэр ажиллаж байгаа байгууллагыг нь уг хүний ажилладаг байгууллага гэж үзнэ.

137. Их дээд, тусгай дунд, техник мэргэжлийн болон срөнхий боловсролын сургуулиудын өдрийн ангид суралцдаг оюутан сурагчид, үндсэн ажлаасаа бүрмөсөн чөлөөлөгдөөд (халагдаад) курст суралцаж байгаа хүмүүсийн ажилладаг байгууллага гэсэн асуултын хариултад уул хүний суралцааг сургууль, курсынх нь нэрийг бичнэ.

138. Ажлаасаа бүрмөсөн чөлөөлөгдөхгүйгээр (халагдаагүй) түр хугацаагаар курст суралцаж байгаа хүний хувьд курст суралцахын өмнөх ажиллаж байсан байгууллагын нэрийг бичнэ.

139. Аль ч байгууллагад харьялагдаагүй чөлөөт зураач, хөгжимчин, зохиолч, уран барималч зэрэг хүмүүсийн ажилладаг байгууллагад «чөлөөт мэргэжил» гэж бичнэ. Харин эдгээр хүмүүс нь тооллогын үед аль нэг байгууллагад ажиллаж байвал тэр байгууллагын нэрийг ажилладаг байгууллага гэсэн асуултад бичнэ.

140. Хоршооллоогүй урчууд, хувиараа үйлдвэрлэл эрхлэгчид, тэдгээрийн хөдөлмөрийн насанд хүрсэн ажил эрхлэгүй гишүүд, амины автомашинаараа бусдад хөлсөөр үйлчилдэг (нөхөрлөлд ороогүй) хүмүүсийн ажилладаг байгууллагыг «хувийн аж ахуйд» гэж бичнэ.

141. Хөлсөөр бусдын хүүхэд асардаг, үйлчлэгч, тогооч хийдэг хүмүүсийн ажилладаг байгууллагад «бусдад хөлсөөр ажилладаг» гэж бичнэ.

142. Сургуулийн өмнөх насын хүүхдүүд, төрөлхийн тахир дутуу, оюуны хомдолтой хүмүүс, улсаас тэтгэвэр авдаггүй хөдөлмөрийн нас хэтэрсэн өндөр настан хүмүүсийн ажилладаг байгууллагад «бусдын асрамж» гэж бичнэ.

143. 0—7 насы болон сургуулийн насын хүүхэд, өн-

дэр настан, өвчтөн асардаг, гэр бүлийн хүний, улирлын ажлын онцлогоос болж ажилгүй байгаа, ямар ч шалтгаангүй ажил хөдөлмөр эрхлээгүй байгаа хөдөлмөрийн насын хумүүсийн ажилладаг байгууллагыг «ажилгүй» гэж бичнэ.

#### НАЙМДУГААР АСУУЛТ. Эрхэлдэг ажил

144. Хүмүүсийн эрхэлдэг ажлыг аль болохоор тодорхой бичнэ. Харин тодотголоороо ялгагдах түгээмэл албан тушаалыг тодотгол нэрийн хамт бичнэ. ЖИШЭЭ нь: «Цэцэрлэгийн эрхлэгч», «Номын сангийн эрхлэгч», «Кино оператор», «Тооцоолон бодох машины оператор», «Барилгын инженер», «Цахилгааны инженер» гэж бичих бөгөөд харин «эрхлэгч», «оператор», «инженер» гэж ерөнхий нэрийг бичиж болохгүй.

145. Сангийн аж ахуй, хөдөө аж ахуйн нэгдэлд ажилладаг хүмүүсийн эрхэлдэг ажлыг ерөнхий нэрээр биш (ЖИШЭЭ нь: малчин) чухам ямар ажил эрхэлдгийг тодорхой нэрээр нь бичнэ. ЖИШЭЭ нь: «Үхэрчин», «Адуучин», «Тракторчин», «Ногоочин», «Саальчин», «Зоотехничк» гэх мэт.

146. Үйлдвэр, аж ахуйн газар, албан байгууллагын захиргааны аппарат, бүх шатны удирдах байгууллагад ажилладаг хүмүүсийн эрхэлдэг ажлыг холбогдох газар, хэлтэстэй нь хамт албан тушаалыг нь бичнэ. ЖИШЭЭ нь: «Боловсон хүний газрын дарга», «Чанаарын хэлтсийн байцаагч», «Санхүүгийн хэлтсийн ерөнхий нягтлан бодогч» гэх мэт.

147. Аль нэгэн байгууллагад ажилладаггүй чөлөөт мэргэжлийн хүмүүсийг «Зураач», «Хөгжимчин», «Зохиолч» гэх мэтээр мэргэжлийн ажлыг бичнэ. Хэрэв чөлөөт мэргэжлийн хүмүүс тооллогын үед ямар нэг байгууллагад ажиллаж байвал, тэр ажлын нь нэрийг бичнэ.

148. Хөдөлмөрийн нөхөрлөл (хоршоолол)-д (үйлдвэр аж ахуйн газар байгууллагад давхар ажилладаггүй) ажилладаг хүмүүс, хоршооллоогүй урчууд, гэрээр үйлдвэр эрхлэгчид, бусдад хөлсөөр ажилладаг хүмүүсийн эрхэлдэг ажлыг тухайн хүний эрхэлдэг гол ажлын нэрээр бичнэ. ЖИШЭЭ нь: «Оёдолчин», «Алт менгөний дархан», «Мужаан», «Тогооч», «Хүүхэд асрагч» гэх мэт.

149. Мэргэжил дээшлүүлэх түр курст суралцагчид, үйлдвэрлэлийн дадлага хийгчдийн «Эрхэлдэг ажил»-ыг курст суралцах, дадлага хийхийн өмнө эрхэлж байсан ажлаар бичнэ.

150. Бүх шатны сургууль, курсад өдрөөр суралцагчид, оюутан, сурагчдын эрхэлдэг ажил гэсэн асуултад анги, курсыг нь зааж бичнэ. **ЖИШЭЭ** нь: «IV курсын оюутан» «7 дугаар ангийн сурагч» гэх мэт.

151. Жирэмсний болон хүүхэд төрүүлсний дараах амралт, хүүхдээ асрах чөлөөтэй байгаа эмэгтэйчүүдийн эрхэлдэг ажлыг амралт, чөлөө авахын нь емнэ эрхэлж байсан ажлаар нөхнэ.

152. Хоёр буюу хэд хэдэн ажил хавсран хийдэг бол аль байгууллагаас нь илүү цалин, орлого авдаг, ажлын цагийн дийлэнх хувийг зарцуулдаг байгууллагад эрхэлдэг ажлаар тухайн хүний ажилладаг байгууллагад эрхэлдэг ажлыг нь нөхнэ.

153. Түр ажил хийж байгаа улирлын ажил эрхэлдэг хүмүүс эрхэлдэг ажил гэсэн асуултад одоо хийж байгаа түр ажлаараа хариулна.

154.Өндөр насын тэтгэвэрт гарсан хүмүүс ямар нэгэн байгууллагад ажиллаж байгаа бол одоо эрхэлж байгаа ажлынх нь нэрийг бичнэ.

155.Өндөр насын тэтгэвэр, тахир дутуугийн группи, улсын бусад тэтгэвэр авдаг хүмүүсийн эрхэлдэг ажлыг ямар төрлийн тэтгэвэр авч байгаагаар нь бичнэ. **ЖИШЭЭ** нь: «Өндөр насын тэтгэвэр», «I, II, III групп», «Тэжээгчээ алдсаны тэтгэвэр» гэх мэт.

156.Хүүхэд, өндөр настан, өвчтөн асардаг болон хөдөлмөрийн насын ямар ч шалтгаангүй ажил эрхлээгүй байгаа хүмүүсийн эрхэлдэг ажил гэдэг асуултыг тодорхой бичнэ. **ЖИШЭЭ** нь: 0—3 насын хүүхэд асардаг», «Гэр бүлийн хүний ажлын онцлог», «Хүнд өвчтөн асардаг» гэх мэт. Харин тодорхой нэрлэх хүндэтгэх шалтгаангүй бол «Ямар ч шалтгаангүй» гэж бичнэ.

#### ЕСДҮГЭЭР АСУУЛТ. Нийгмийн гарал

157.Хүний төрөх үед эцэг, эхийнх нь нийгмийн байдал тухайн хүний нийгмийн гарал болно. Тухайн хүний хариултыг үндэслэж «Ажилчин», «Албан хаагч (Сэхээтэн)», «Малчин ард», «Хоршоолсон ард», «Бусад» гэсэн нийгмийн гарлын ангиллаас аль тохиорохыг нь олж доогуур нь зурна.

158. **Ажилчин.** Улс, олон нийтийн байгууллага (хөдөө аж ахуйн нэгдлээс бусад)-д голчлон биеийн хөдөлмөр эрхлэн нийгмийн материаллаг баялгийг бүтээх процесст оролцогчид, тэдгээрийн асрамжид байдаг гэр бүлийн нь хүмүүс, энэ бүлэгт байгаад өндөр насын тэтгэвэрт гарагчдыг нийгмийн «ажилчин» бүлэгт хамааруулна.

цогчдыг «Ажилчин» гэнэ. **ЖИШЭЭ** нь: эцэг (эх) нь өрөмдөгч, малтагч, өрлөгчин, шаварчин, бүх төрлийн машины жолооч, оёдолчин, нэхмэлчин, мужаан, худалдагч, ачигч, сангийн аж ахуйн адуучин, үхэрчин, саальчин зэрэг ажил эрхэлж байсан бол «ажилчин» гаралтай гэж үзнэ.

159. **Албан хаагч (сэхээтэн).** Улс, олон нийтийн байгууллагад голчлон оюуны хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүсийг «албан хаагч (сэхээтэн)» гэнэ. **ЖИШЭЭ** нь: эцэг (эх) нь улс, олон нийтийн байгууллага, үйлдвэр, аж ахуйн газар, албан байгууллагын дарга, орлогч дарга, эдийн засагч, инженер, багш, хүн, малын эмч, зоотехникч зэрэг ажил эрхэлж байсан бол «албан хаагч (сэхээтэн)» гаралтай гэж үзнэ.

160. **Малчин ард.** Тухайн хүнийг төрөх үед эцэг (эх) нь хөдөө аж ахуйн нэгдлийн гишүүн биш, ардын (хувийн) аж ахуйтан байж, мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж байсан бол уг хүний нийгмийн гарлыг «Малчин ард» гэнэ.

161. **Хоршоолсон ард.** Тухайн хүнийг төрөх үед эцэг (эх) нь хөдөө аж ахуйн нэгдэл, гар үйлдвэрийн хоршооллын гишүүд байсан бол уг хүний нийгмийн гарлыг «Хоршоолсон ард» гэнэ.

162. **Бусад.** Эцэг (эх) нь энэ зааврын 158—161-д заагдсанаас бусад ажил эрхэлж байсан хүмүүсийг «бусад» гаралтай гэж үзнэ.

#### АРАВДУГААР АСУУЛТ. Нийгмийн бүлэг

163. Тухайн хүний ажилладаг байгууллага, эрхэлдэг ажлыг үндэслэн нийгмийн ямар бүлэгт хамаарагддаг болохыг тодорхойлно. Нийгмийн бүлгийг «ажилчин», «албан хаагч (сэхээтэн)» «хоршоолсон ард», «бусад» гэсэн дөрвөн бүлэгт хуваана. (Нийгмийн бүлгийг тодорхойлоход бэрхшээлтэй зарим ажил эрхлэлтийн жагсаалтыг хавсралт № 9-өөс үзэж ашиглана уу).

164. **Ажилчин.** Улс, олон нийтийн байгууллагад (хөдөө аж ахуйн нэгдлээс бусад) голчлон биеийн хөдөлмөр эрхэлж, нийгмийн баялгийг бүтээх процесст оролцогчид, тэдгээрийн асрамжид байдаг гэр бүлийн нь хүмүүс, энэ бүлэгт байгаад өндөр насын тэтгэвэрт гарагчдыг нийгмийн «ажилчин» бүлэгт хамааруулна.

165. **Албан хаагч (сэхээтэн).** Улс, олон нийтийн байгууллагад голчлон оюуны хөдөлмөр эрхлэгчид тэдгээрийн асрамжид байдаг гэр бүлийн нь хүмүүс, энэ бүлэгт бай-

гаад өндөр насын тэтгэвэрт гарагчдыг «албан хаагч (сэхээтэн)» гэнэ.

166. **Хоршоолсон ард.** Хөдөө аж ахуйн нэгдлийн гишүүд, нэгдлээс өндөр насын тэтгэврт гарагчид, тэдний асрамжид байдаг хүмүүсийн нийгмийн бүлгийг «хоршоолсон ард» гэнэ.

Хөдөө аж ахуйн нэгдлийн гишүүн биш, нэгдлийн үйлдвэрлэлийг шууд удирдан зохион байгуулдаг нэгдлээс цалинждаг малын эмч, зоотехникч, агрономч зэрэг хүмүүсийн нийгмийн бүлгийг «хоршоолсон ард» гэж нөхнэ.

167. **Бусад.** Энэ зааврын 164—166-д заагдсанаас бусад хүмүүсийн нийгмийн бүлгийг «бусад» гэнэ.

168. 16 хүртэлх насын хүүхдүүд, 16-аас дээш насын боловч тодорхой шалтгаанаар бусдын асрамжид байдаг хүмүүсийн нийгмийн бүлгийг, өрхийн трэгүүлэгч буюу асран хамгаалагчийн нийгмийн бүлгийг дагуулж бичнэ.

169. Ерөнхий боловсролын сургууль төгсөөд шууд их, дээд, тусгай мэргэжлийн дунд, техник мэргэжлийн сургууль, курст суралцаж байгаа хүмүүсийн нийгмийн бүлгийг тэр хүний эцэг (эх), бусад асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн нийгмийн бүлгийг дагуулж бичнэ.

170. Ажиллаж байгаад сургууль, курст орж суралцагчид, тахир дутуугийн группэд байгаа хүмүүсийн нийгмийн бүлгийг оюутан, сурагч болох, группэд орохоос өмнө хамарагдаж байсан нийгмийн бүлгээр тодорхойлно.

171. Ямар нэгэн албан байгууллагын орон тоонд ажилладаггүй чөлөөт мэргэжлийн хүмүүс (зохиолч, зураач, хөгжимчин, барималчин гэх мэт)-ийг «албан хаагч» (сэхээтэн) гэж нөхнэ.

#### АРВАННЭГДҮГЭЭР АСУУЛТ. Амьдралын (орлогын) эх сурвалж

172. **Үйлдвэр,** аж ахуйн газар, албан байгууллага. Улс, олон нийтийн (хөдөө аж ахуйн нэгдлээс бусад) аль нэг байгууллагад ажил өрхэлдэг хүмүүсийн амьдралын (орлогын) эх сурвалжийг «үйлдвэр, аж ахуйн газар, албан байгууллага» гэж нөхнэ.

173. **Хөдөө аж ахуйн нэгдэл.** Хөдөө аж ахуйн нэгдэл, нэгдэл дундын үйлдвэр, хоршоололд ажил өрхэлж, цалин хөлсөө нэгдлээс авдаг бүх хүмүүсийн амьдралын (орлогын) эх сурвалжийг «хөдөө аж ахуйн нэгдэл» гэж нөхнэ.

174. **Өндөр насын тэтгэвэр авдаг боловч байнга ажил**

эрхэлдэг хүмүүсийн амьдралын (орлогын) эх сурвалжийг одоо ажиллаж байгаа, мэргэжил дээшилүүлэх болон давтан сургууль, курст суралцагчид, хүүхэд асрах чөлөөтэй байгаа эмэгтэйчүүдийн амьдралын (орлогын) эх сурвалжийг ажиллаж байсан «үйлдвэр, аж ахуйн газар, албан байгууллага», «хөдөө аж ахуйн нэгдэл»-ийн аль тохириохор нь хариулна.

175. **Өндөр насын тэтгэвэр.** Өндөр насын тэтгэвэр авагчдын (өндөр насын тэтгэвэр авдаг боловч байнга ажил өрхэлдэг хүмүүс орохгүй) амьдралын (орлогын) эх сурвалжийг «өндөр насын тэтгэвэр» гэж нөхнэ.

176. **Стипенди.** Их, дээд, тусгай мэргэжлийн дунд, ТМС-ийн өдрийн ангид суралцаж (орой, эчнээ салбарт суралцагчид орохгүй) стипенди авдаг хүмүүсийн амьдралын (орлогын) эх сурвалжийг «стипенди» гэж нөхнэ.

177. **Улсын бусад тэтгэвэр тэтгэмж.** Улсын асрамжийн газарт асуулж сувилуулагчид, хүүхдийн асрамжийн газар, сургуульд хүмүүжиж буй хүүхэд, сурагчид, тэжээгчээ алдсаны тэтгэвэр, тэтгэмж, тэтгэмж авагчдын амьдралын (орлогын) эх сурвалжийг «улсын бусад тэтгэвэр, тэтгэмж» гэж нөхнэ.

178. **Бусдын асрамж.** Сургуулийн өмнөх насын хүүхэд, ЕБС-ийн сурагчид, ажил хөдөлмөр өрхэлдэггүй бусдын асрамжид байдаг, биеэ даасан амьдралын эх сурвалжгүй хүмүүсийн амьдралын (орлогын) эх сурвалжийг «бусдын асрамж» гэж нөхнэ.

179. **Амины туслах аж ахуй.** Хувийн хөдөлмөр, амины туслах аж ахуй өрхэлдэг (нэгдлээс өндөр насын тэтгэвэр авдаггүй) хөдөлмөрийн нас хэтрэгчид, хувиараа үйлдвэрлэл өрхэлдэг хүмүүс тэдийн гэр бүлийн ажилгүй 16-аас дээш настай хүмүүс бусад иргэдийн амьдралын эх сурвалжийг «амины туслах аж ахуй, хувийн хөдөлмөр» гэж нөхнэ.

179а. Хөдөлмөрийн нөхөрлөл, хоршоололд ажилладаг, орлогынхоо ихэнхийг тэндээс авдаг бол амьдралын эх сурвалжийг «хөдөлмөрийн нөхөрлөл (хоршоолол)»-гэж нөхнэ. Гэхдээ үйлдвэр, аж ахуйн газар, байгууллагад ажилладаг, ажлын бус цагаар хөдөлмөрийн нөхөрлөл (хоршоолол)-д давхар ажилладаг бол тэр хүний амьдралын эх сурвалжийг «үйлдвэр, аж ахуйн газар, байгууллага» гэж нөхнэ.

180. Бусад хэлсөөр ажиллагчид (хүүхэд асрагч, тоогооч, үйлчлэгч гэх мэт), чөлөөт мэргэжлийн хүмүүс, орон

сууцаа хөлслүүлэх, хувийн хадгаламжийн орлого зэрэг эх сурвалжаар амьдардаг хүмүүсийн амьдралын эх сурвалжийг «бусад эх үүсвэр» гэж иехнэ.

#### АРВАН ХӨРДҮГААР АСУУЛТ. Боловсрол

181. **Бүрэн дээд.** Дотоод, гадаадын их, дээд сургууль төгссөн хүмүүсийг «бүрэн дээд» боловсролтой гэж үзнэ. Багшийн дээд сургуулийг 1959 оноос өмнө төгсөөд давтан курст суралцаж төгссөн хүмүүсийг бүрэн дээд боловсролтойд тооцно.

182. **Бүрэн бус дээд.** Их, дээд сургуулиудад суралцах хугацааныхаа ихэнхийг суралсан болон одоо суралцаж байгаа хүмүүс, оюутнууд, намын дээд сургуулийг 1966 оноос, Багшийн дээд сургуулийг 1959 оноос өмнө төгсөгчид, Марксизм-Ленинизмын оройн дээд сургууль, Дорно дахини хөдөлмөрчдийн их сургууль (КУТВ), Намын дээд сургуулийн дэргэдэх хоёр жилийн курс төгсөгчдийг бүрэн бус дээд боловсролтойд тооцно.

183. **Тусгай мэргэжлийн дунд.** Гадаад, дотоодын техникум, тусгай мэргэжлийн дунд сургууль, хөгжим бүжгийн дунд сургууль төгсөгчдийг «тусгай мэргэжлийн дунд» боловсролтойд тооцно.

184. Ерөнхий боловсролын сургууль, Хөдөлмөрчдийн ерөнхий боловсролын сургуулийн 10 дугаар анги төгсөгчдийг бүрэн дунд, 7 дугаар анги (хуучин системээр), 8 дугаар анги төгсөгчдийг бүрэн бус дунд, 4 дүгээр анги (хуучин системээр), 3 дугаар анги төгсөгчдийг бага боловсролтойд тооцно.

185. **Бичиг мэддэг, бичиг мэддэггүй** гэсэн асуултыг ямар нэгэн боловсролгүй 11-ээс дээш насын хүмүүс хариулна. Монголын шинэ, хуучин бичгийн аль нэгийг болон ямар нэг улсын бичгийг ушиж бичдэг байвал бичиг мэддэгт тооцно. Харин уншиж чаддаггүй бол бичиг мэддэггүй гэж үзнэ.

186. ЕБС-ийн 2, 3 дугаар ангид суралцаж байгаа хүүхдүүдийг «бичиг мэддэг» гэж хариулна.

187. ЕБС-ийн нэгдүгээр ангид суралцдаг, сургуульд ороогүй, оюуны хомдолтой 9-өөс доош насын хүүхдүүд «боловсрол» гэдэг үзүүлэлтийг бөглөхгүй.

30

#### АРВАН ГУРАВДУГААР АСУУЛТ. Мэргэжлээр

188. Энэ асуултын хариултыг аль болохоор нарийн мэргэжлээр нь тодорхой бичнэ. ЖИШЭЭ нь: «Хэл утга зохиолын багш», «Тоо физикийн багш», «Мэс заслын их эмч», «Хүүхдийн их эмч», «Шүдний их эмч», «Төлөвлөгчэдийн засагч», «Санхүү эдийн засагч», «Уул уурхайн инженер», «Дулааны инженер» гэж дипломд бичсэн мэргэжлээр нь бичих шаардлагатай. Харин «багш», «хүний их эмч», «эдийн засагч» «инженер» гэж бичиж болохгүй.

189. Харин тухайн хүн хэд хэдэн мэргэжилтэй бол дээд төвшингийн мэргэжлийг, ижил төвшингийнх бол ажиллаж байгаа мэргэжлээр нь авна.

#### АРВАН ДӨРӨВДҮГЭЭР АСУУЛТ. Гэрлэлтийн байдал

190. **Гэрлэсэн.** Гэрлэлтээ бүртгүүлсэн эсэхийг харгалзахгүйгээр тухайн хүн эхнэртэй (нэхэртэй) гэж хариулбал «гэрлэсэн» гэдгийн доогуур зурна.

**ТАЙЛБАР.** Гэрлэлтийн байдал гэсэн энэ асуултад 18-аас дээш насын хүмүүс хариулна.

Гэвч 18-аас доош насын хүмүүс гэрлэсэн тохиолдол байвал тэдгээр хүмүүсийн хувьд «гэрлэсэн» гэдгийг нэгэн адил зурна.

191. **Бэлбэсэн.** Эхнэр, нэхрийн аль нэг нь нас барсан дахин гэрлээгүй хүмүүсийн хувьд «бэлбэсэн» гэдгийн доогуур зурна.

192. **Салсан.** Гэр бүлээсээ салсан дахин гэрлээгүй хүмүүст «салсан» гэдгийн доогуур зурна.

193. **Огт гэрлээгүй.** Арван найм түүнээс дээш насын хүмүүс гэрлээгүй бол «огт гэрлээгүй» гэсний доогуур зурна.

#### АРВАН ТАВДУГААР АСУУЛТ. Төрүүлсэн хүүхдийн тоо

194. **Төрүүлсэн хүүхдийн тоо.** Энэ асуултад зөвхөн эмэгтэйчүүд хариулна. Амьд төрүүлсэн нийт хүүхдийн (хүүхдийн нас, хамт амьдардаг, тусдаа байдаг, нас барсныг харгалзахгүйгээр) тоог бичнэ. Төрүүлсэн хүүхдийн тоонд үрчлүүлсэн болон асрамжид өгсөн хүүхдээ оруулна.

Хүүхэд төрүүлээгүй 18 ба түүнээс дээш насын эмэг-

31

тэйчүүд тооллогын хуудасны энэ асуултын хариултад зураас тавина. Харин 18-аас доош настай эмэгтэй хүүхэд төрүүлсэн бол тоог бичнэ.

195. **Одоо эих тунх амьдарч байгаа.** Энэ асуултад төрүүлсэн нийт хүүхдүүдээс тооллогын үед амьд байгаагий нь нас харгалзахгүйгээр сугалж бичнэ.

#### ЗҮРГАА. Өрхийн хуудас бөглөх заавар

196. Тоологч, тухайн 1 суур (гэр)-д хэдэн өрх амьдарч байгааг заавал тодруулж өрх бүрт тус тусад нь өрхийн хуудас нээнэ.

**ТАЙЛБАР:** Өрх үүсгэхгүйгээр хамт амьдарч байгаа дараах хүмүүсийн хувьд өрхийн хуудасны зөвхөн орон сууцны хэсгийг өрөөгөөр нь нөхнө. Үүнд:

а) гадаад, дотоодын их, дээд, тусгай мэргэжлийн дунд, ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд суудаг оюутан, сурагчид;

б) ажилчны нийтийн байранд ураг төрлийн холбоогүй нэг дор амьдарч буй хүмүүс.

197. Тоологч бүр тоолсон өрхөө дэс дараалан дугаарлана. Тоологчийн тоолсон өрхийн тоо сүүлчийн өрхед нээсэн өрхийн хуудасны дугаартай тэнцүү байна.

198. **Тооллогын комисс, хэсгийн №.** Энэхүү зааврын 96 дугаар зүйлд заасныг баримтална.

199. **Аймаг (хот), сум (район, хороо).** Энэхүү зааврын 97, 101—102, 106 дугаар зүйлд заасныг баримтална.

200. **Өрхийн №.** Энэхүү зааврын 196, 197 дугаар зүйлийг баримтална.

**ТАЙЛБАР:** Өрхийн хуудас нь тооллогын хуудас нөхөхөөс өмнө бөглөгдөх учраас тооллогын хуудаст бичигдэх өрхийн дугаарыг өрхийн хуудаснаас шууд хуулж бичнэ. Иймд тооллого, өрхийн хуудсанд бичигдсэн өрхийн дугаарууд ижил байна.

201. **Өрхийн ам бүлийн тоо.** Ураг төрлийн болон гэр бүлийн холбоотой нэгдмэл төсөвтэй нэг орон байранд хамт амьдардаг хүмүүсийг тухийн өрхийн ам бүлд хамруулдаг. Гэтэл тооллогын үед тухийн өрх айлд өрхийн үндсэн гишүүдээс гадна өрхийн ам бүлд орохгүй садан төрөл, бусад хүмүүс амьдарч байхаас гадна, өрхийн ам бүлээс өөр

газар яваа (цэрэг, оюутан сурагчид, түр хугацааар явагсад) хүмүүс ч гарна.

«Өрхийн ам бүлийн тоо» гэсэн үзүүлэлтэд тухайн өрхийн ам бүлийн нийт гишүүдийн тоог бичнэ. Өрхийн ам бүлийн тоо, тухайн өрхэд тоологдсон хүн амын тоо болон байнга амьдардаг гишүүдийн тоотой тэнцүү биш байж болно.

**ТАЙЛБАР:** Өрхийн хуудасны «б» хэсэгт зөвхөн хамт амьдардаг ам бүлийн гишүүдийг бичнэ (гэр бүлээсээ тусдаа байгаа цэрэг, оюутан сурагч нь байгаа газартаяа тоологдох болно).

202. **Ажил өрхэлдэг.** Энэ асуултад тухайн өрхийн ам бүлээс улс, хоршоолол, олон нийтийн аль нэгэн байгууллагад тодорхой жил өрхэлж байгаа хүмүүсийн тоог сугалж бичнэ.

203. **0—16 хүртэл насны хүүхэд.** Энэ асуултад тухайн өрхийн ам бүлийн тооноос 0—16 хүртэл (15 нас 12 сар 30 хоногоос доош) насны хүүхдийн тоог сугалж бичнэ. Хүүхдийг зөвхөн насаар нь ангилж байгааг тоологч пар анхаарах хэрэгтэй. Иймд хөдөлмөрийн нас хүрээгүй боловч ажил өрхэлдэг хүүхдүүд өрхийн ам бүлийн тоонд ороод түүнээсээ ажил өрхэлдэг ба 0—16 хүртэл насны хүүхэд гэж 2 удаа сугарч байгааг анхаарах хэрэгтэй.

204. **Хаяг.** Тухайн өрх тооллогын үед хот, хот маягийн суурин, сум (хороо)-ын төв, бригад, хэсгийн төв, хөдөөгийн чухам алийн байгааг тодорхойлж зурна. Өрхийн гишүүдийн тооллогын хуудасны хаяг, энэ маягтай тохирч байна.

205. **Овог нэр (энэ зааврын 98), нас (энэ зааврын 114—116), эрэгтэй, эмэгтэй (энэ зааврын 113), байнга суудаг, түр суугаа, түр эзгүй (энэ зааврын 108—111), нийтмийн бүлэг (энэ зааврын 163—171), гэрлэлтийн байдал (энэ зааврын 190—193), өрхэлдэг ажил (энэ зааврын 144—156), өрхийн тэргүүлэгчтэй ямар хамааралтай болох (энэ зааврын 107) гэсэн үзүүлэлтийг нөхөхдөө энэ зааврыг баримтална.**

**ТАЙЛБАР:** Тооллогын хуудсыг нөхөх үед асуултыг хариултын доогуур зурдаг бол өрхийн хуудсыг нөхөхдөө хүснэгтийн «өгүүлэхүүн»-д байгаа асуултыг хариултыг шифрийн хамт зориулалтын

зайнд бичдэгээр ялгаатай (маягтад  
өгсөн загварыг үз).

206. Эрхийн хуудсанд бичигдсэн бүх хүнд тооллогын хуудас нөхнө. Учир нь энэ зааврын 201-д бичигдсэн тайлбарын дагуу эрхийн хуудсанд зөвхөн хамт амьдардаг хүмүүсийг бичих юм.

207. Эрхийн ам бүлийн тоо, үүнээс ажил эрхэлдэг, 0—16 хүртэл насны хүүхэд гэсэн үзүүлэлтүүдийг (эрхийн ам бүлийн нийт гишүүдийг эрхийн хуудсанд бичсэний дараа) одоо уг өрхөд байхгүй боловч ам бүлд нь ордог хүмүүсийг асууж тодруулах журнаар нөхнө.

#### Орон сууцны асуулт нөхөх талаар

208. Тоологч нар, орон сууцны холбогдолтой асуултыг нөхөхдөө тухайн сууц (байшин гэрт)-д хэдэн өрх айл амьдрал сууж байгааг тодруулсан байвал зохино. Хэрэв нэг сууд (гэр)-д хоёр буюу түүнээс дээш өрх амьдардаг бол уг сууц (гэр)-д амьдардаг өрхүүд хамтран эзэмших ордер гэрээтэй, эсвэл нэг нь эзэмшиж нөгөө нь хувийн журнаар сууж байгааг урьдчилан мэдсэн байх шаардлагатай.

209. Тоологчид тухай нэг өрх, амины байшин, гэр аль алинтай нь юмуу эсвэл улс, хоршооллын байгууллагын байшин (гэр)-д суугаад мөн амины гэртэй тохиолдолд байшин, гэр 2-ын чухам алинд нь амьдардгийг эхлээд тодруулсаны дараа орон сууцны байшин, гэрийн аль тохиорхыг нөхнө. Харин нэг өрх, орон сууц, гэр байшин хоёулантай байж тооллогын үед хуудасны а) байшин, б) гэр хэсгийг хоёулангий нь нөхөж, оршин суугчдын тоо гэсэн асуултад тэдгээрт амьдрал суугчдын тоог давхардуулахгүйгээр тус тусад нь сууж байгаа хүнээр нь нөхнө.

210. Бусдын сууц (байшин, гэрт)-д өөр өрхтэй хамт амьдардаг «ганц бие», «гэр бүлээсээ тусдаа», хүмүүсийг тусгай өрх гэж үзэхгүй, тухайн эрхийн байнга суугчдын тоонд оруулна.

211. Гадаад орнуудад болон өөр газар явсан айлын сууцанд түр сууж байгаа өрх, хүмүүсийг тухайн сууцыг эзэмшигчээр тоолно.

212. **Сууцны төрөл.** Орон сууцыг төрлийн хувьд бие даасан тусгай сууц, бие даасан тусгай сууцны хэсэг, нийтийн байр, оюутан сурагчдын дотуур байр гэж 4 ангиана;

а) бие даасан тусгай сууц. Бүтэц хийц, зохион байгуулалтын хувьд өрх айл суухад зориулан тохижуулсан нэг буюу хэд хэдэн өрөө тасалгаатай байрыг «бие даасан тусгай сууц» гэж үзнэ;

б) бие даасан тусгай сууцны хэсэг. Орон сууц ашиглалтын байгууллага, үйлдвэр, албан газрууд нэг өрх (айл) суух зориулалттай сууцыг хоёр өрх айлд эзэмшүүлэхээр тус тусад нь гэрээ ордер олгосон, мөн амины сууцны нэг байшингийн өрөөнүүдийг хоёр ба түүнээс дээш өрх айл хамт эзэмшиж сууж байвал, уг сууцыг «бие даасан тусгай сууцны хэсэг» гэж үзнэ.

Бие даасан тусгай сууцанд 2 ба түүнээс дээш өрх амьдарч байгаа тохиолдолд (орон сууц ашиглалтын байгууллага, үйлдвэр, аж ахуйн газар байгууллагын зөвшөөрөлтэй эсэхийг харгалзахгүйгээр) тэр сууцыг эзэмшигч нэгээс бусад өрхүүд нь бие даасан тусгай сууцны хэсэгт амьдардаг гэж үзнэ.

Тооллогод орон сууцны хангамж, нөхцөлийг судлахын тулд «бие даасан сууцны хэсэг» гэсэн үзүүлэлтийг нэмж оруулсан юм. Тооллогын материалыг боловсруулахдаа «бие даасан тусгай сууц», «бие даасан тусгай сууцны хэсэг» хоёрыг ялгахын тулд «сууцны доторх эрхийн дараалал» гэсэн асуулт орууллаа.

**ТАЙЛБАР:** Тоологч нар нэг сууцанд хамт амьдардаг өрхүүд 1, 2, 3 гэж дугаартай байгаа нь сууц эзэмшихэд ямар ч холбогдолгүй гэдгийг сайтар ойлгуулж ямар өрхийг 1-д бичихийг зөвхөн тэдний сайн дурын үндсэн дээр шийдвэрлэнэ. Өөрсдөө шийдвэрлэж чадахгүй тохиолдолд тоологч аль нэг эрхийг сонгож бичнэ.

1 гэж бичсэн эрхийн тооллогын хуудсанд тухайн сууц, амины байшингийн өрөөний тоо, ашигтай ба сууцны талбайн хэмжээ, сууж байгаа бүх өрх, байнга суугчдын тоо, төхөөрөмжлэгдсэн байдлыг сууц, байшингийн нийт хэмжээгээр бичнэ. Харин 2, 3, 4 гэх мэт бичсэн эрхийн хувьд орон сууцны төрлийг нь «Бие даасан тусгай сууцны хэсэг» гэж үзэж, эрхийн хуудсанд нь орон сууцны холбогдолтой үзүүлэлтийг нөхөхдөө зөвхөн тэр эрхийн эзэмшдэг өрөөний тоо, сууцны талбайн хэмжээ (ashiгтай талбайг

суудны талбайтай тэнцүү авна) өөрийн нь ам булийн гишүүдийн тоог бичих бөгөөд төхөөрөмжлөгдсөн байдал нь нэг гэж бичигдсэн өрхийнхтэй адилхан байна;

в) **нийтийн байр.** Үйлдвэр, аж ахуйн газар, албан байгууллагын ажилчийн, албан хаагчдын шийтээр суухад зориулац төхөөрөмжлөгдсөн байрыг «Нийтийн байр» гэж үзнэ;

г) **оюутан сурагчдын досгуур байр.** Их, дээд, тусгай мэргэжлийн дунд, техник мэргэжлийн болон өрөөний боловсролын сургуулиудын оюутан сурагчид нийтээр суухад зориулац төхөөрөмжлөгдсөн байрыг «оюутан сурагчдын дотуур байр» гэж үзнэ.

213. **Байшингийн өмчийн хэлбэр.** Байшинг өмчийн хэлбэрийн хувьд улсын, ХАА-н нэгдэл, нэгдэл дундын хоршооллын, хувь нийлүүлсэн байгууллагын (Улаанбаатар төмер зам гэх мэт), хоршооллын, өөрийн хөрөнгөөр барьсан амины, зээлийн хөрөнгөөр барьсан амины гэж ангилаа.

а) **улсын.** Улс, олон нийтийн байгууллагын (яам, тусгай газар, үйлдвэр, албан байгууллага, сангийн аж ахуй зэрэг) мэдэлд байгаа (улсын өмч) орон сууцыг «Улсын орон сууд» гэж үзнэ;

б) **ХАА-н нэгдэл, нэгдэл дундын хоршооллын.** Хөдөө аж ахуйн нэгдэл, нэгдэл дундын хоршооллын өмчид байгаа орон сууцыг «нэгдэл, нэгдэл дундын хоршооллын орон сууд» гэж үзнэ;

в) **хувь нийлүүлсэн байгууллагын.** Төмөр зам, Сомонголцвстмет нэгдэл гэх мэт хоёр улсын хувь нийлүүлсэн байгууллагын өмчид байгаа сууцыг «хувь нийлүүлсэн байгууллагын орон сууд» гэж үзнэ;

г) **хоршооллын.** Улаанбаатар хотын «Багш», «Энэрэл» гэх мэт хувь хүмүүс хоршооллон эзэмшдэг сууцыг «хоршооллын орон сууд» гэж үзнэ;

д) **амины сууцыг өөрийн хөрөнгөөр, зээлийн хөрөнгөөр барьсан** гэж 2 ангилик нөхнө.

Хувь хүмүүс өөрсдийн хүч хөрөнгөөр барьсан сууцыг «өөрийн хөрөнгөөр», банкны байгууллагаас зээл авч барьсан амины сууцыг «зээлийн хөрөнгөөр барьсан амины байшин» гэнэ.

214. **Сууд (гэр)-ны доторх өрхийн дараалал.** 1 сууд (гэр)-д хоёр буюу түүнээс дээш өрх хамт амьдарч байгаа нэхцэлд эдгээр өрхүүдийг суудны дотор 1, 2, 3 гэх мэтээр дэс дараалан дугаарлана. Аль өрхийг 1 дүгээр өрх гэж би-

чихийг өрхүүд өөрсдөө тодорхойлно. Тухайн өрхүүдэд өгсөн дугаарыг (1, 2, 3 гэх мэт) сууд (гэр)-ны доторх өрхийн дараалал гэсэн үзүүлэлтийн ар талд байгаа нүхэнд бичсэн байна. Энэ дугаар нь зөвхөн тэр сууд (гэр)-д амьдардаг өрхийн дэс дараалал учир тоолсон өрхийн дугаараас ялгаатай гэдгийг тоологч нар анхаарвал зохино.

1 іэж бичигдсэн өрхийн хувьд орон сууцыг «бие даасан тусгай сууд» (хамтран эзэмшдэг ч байсан) гэж үзнэ. (Энэ зааврын 212 дугаар зүйлийн б хэсгийн тайлбар, 215-дугаар зүйл).

215. Нэг сууд (гэр)-д хоёр буюу түүнээс дээш өрх байгаа тохиолдолд өрөөний тоо, ашигтай ба суудны талбайн хэмжээ, төхөөрөмжлөгдсөн байдал, сууж байгаа өрх, байнга суугчдын тоог 1-д бичигдсэн өрхийн хуудсанд тухайн сууд, байшин, өөрийн нийт дүнгээр нь бусад (2, 3 дахь) өрхийн хуудсанд зөвхөн тэр өрхийн эзэмшиж байгаа өрөөний тоо, суудны талбайн (ashiгтай талбайг суудны талбайтай тэнцүүгээр авна) хэмжээ, байнга суугчдын тоог тус тусад нь сугалж бичнэ.

216. Суудны нэг байшин (гэр)-д хамт амьдардаг өрхүүдэд суудны төрөл, байшингийн өмчийн хэлбэр, төхөөрөмжлөгдсөн байдал гэсэн үзүүлэлтүүд адилхан байна.

217. **Өрөөний тоо.** Тухайн суудны өрөөний тоог зөвхөн тоо (1, 2, 3, 4 гэх мэт)-гоор энэ зааврын 212 дугаар зүйлийн б хэсгийн тайлбар, 215 дугаар зүйлд заасныг баримталж бичнэ.

218. **Ашигтай талбай.** Орон суудны ашигтай талбай нь суудны талбай (амралт, зочин, ажлын өрөө) дээр туслах өрөө тасалгаа (коридор, гал тогоо, онгоц шүршүүр, агуулах, ариун цэврийн өрөө зэрэг)-шуудын талбайн хэмжээт нэмсэнтэй тэнцүү байна. 1-д бичигдсэн өрхийн хувьд ашигтай талбайг нийт суудны хэмжээгээр гаргаж бичих ба бусад өрхийн хувьд зөвхөн эзэмшдэг өрөөний суудны талбайн хэмжээг бичнэ.

219. **Суудны талбай.** Орон суудны амралт, зочин, ажлын өрөөнүүдийн талбайн нийлбэрийг «Суудны талбай» гэнэ. 1-д бичигдсэн өрхийн хувьд суудны талбайг нийт суудны хэмжээгээр гаргаж бичих ба бусад өрхийн хувьд зөвхөн эзэмшдэг өрөөний талбайн хэмжээг бичнэ.

220. Орон сууд эзэмшигч, өрөөний ашигтай болон суудны талбайн хэмжээг мэдэхгүй бол тоологч нар орон суудны гэрээнээс тодруулах буюу өөрсдөө хэмжиж тогтооно.

**221. Сууж буй өрхийн тоо.** 1-д бичигдсэн өрхийн хувьд тухайн байшин, гэрт амьдрал сууж байгаа нийт өрхийн тоо, бусад өрхийн хувьд 1 гэж байна.

**222. Байнга суугчдын тоо.** 1-д бичигдсэн өрхийн хувьд тухайн байшин гэрт тогтмол амьдрах суудаг хүний тоо, бусад өрхийн хувьд зөвхөн тэр өрхийн байнга суудаг гишүүдийн тоог бичнэ.

#### Техеөрөмжлэгдсэн байдал

**223. Халаалт.** Орон суудны халаалтыг эх үүсвэрийн хувьд «төвлөрсөн», «төвлөрсөн бус», «ердийн» халаалттай гэж З ангилна:

а) **төвлөрсөн халаалттай.** Дулааны цахилгаан станцу болон аж үйлдвэрийн газрын уурын зуухтай холбогдсон халаалтын систем бүхий сууцыг «төвлөрсөн халаалттай» гэж үзнэ;

б) **төвлөрсөн бус халаалттай.** Тусгайлан баригдсан уурын зуухтай холбогдсон халаалтын систем бүхий сууцыг «төвлөрсөн бус халаалттай» гэж үзнэ;

в) **ердийн халаалттай.** Ердийн зуух, пийшинтэй сууцыг «ердийн халаалттай» гэж үзнэ.

Дээрх гурван төрлийн халаалтын системээс аль тохиорх нэгийг олж түүний ард байгаа шифрийг дугуйлж тэмдэглэсэн байна.

**224. Ус түгээгүүр.** Тухайн сууц халуун, хүйтэн устай, зөвхөн хүйтэн устай, байшингийн дотор нийтийн зориулалттай халуун, хүйтэн (зөвхөн хүйтэн устай байж болно) устай, эсвэл байшингийн гадна (худгаас гараар зөөдөг, зөөврийн усаар хангагддаг) аль нь болохыг тодруулж зурна.

**225. Бохир усны татуурга.** Тухайн сууц, сууц дотроо, байшингийн дотор нийтийн юмуу байшингийн гадна бохир усны татуургатай аль нь болохыг тодруулж тохиорох хариултын ар талд байгаа шифрийг дугуйлж зурна.

**226. Гал тогооны өрөө.** Гал тогооны тусгай ба нийтийн өрөөтэй юмуу гал тогооны өрөөгүй гэсэн 3 хариултаас аль тохиорохыг олж, ард талд байгаа шифрийг дугуйлж зурна.

**227. Онгоц шүршүүрийн өрөө.** Онгоц шүршүүрийн өрөөтэй, өрөөгүй, байшингийн дотор нийтийн өрөөтэй аль нь болохыг тодруулж хариултын ар талд байгаа шифрийг дугуйлж зурна.

**228. Хог дамжуулах хоолой.** Байшин хог дамжуулах

хоолойтой, хоолойгүй аль нь болохыг тодруулж хариултын ар талд байгаа цифрийг дугуйлж зурна.

**229. Цахилгаан.** Тухайн сууц цахилгаан гэрэлтэй, гэрэлгүй, зуух (пийшин)-тэй, зуух (пийшин)-гүй, байшин цахилгаан шаттай, шатгүй гэдгийг тогтоож хариултын ар талд байгаа шифруүдийг дугуйлж зурна.

Цахилгаан хангамжтай боловч тооллогын үед түр тасалсан, цахилгаан зуух, шаттай боловч ажилгүй, эвдэрсэн, засварт байгаа тохиолдолд цахилгаан гэрэлтэй, цахилгаан зуухтай, цахилгаан шаттай гэж үзнэ.

#### 6 ) гэр

**230. Гэрийн доторх өрхийн дараалал** гэсэн үзүүлэлтийг энэ зааврын 214 дугээр зүйлд заасны дагуу нөхнэ. Гэрт дангаараа нэг өрх байвал «гэрийн доторх өрхийн дараалал» гэсэн үзүүлэлтэд 1 гэж заавал бичнэ. Зарим тохиолдолд 1 өрх 2 гэрт амьдрах нь бий. Ийм тохиолдолд 2 өрх гэж үзэж тус тусад нь өрхийн хуудас нээж, орон суудны үзүүлэлтийг нөхнэ.

**231. Айл өрхийн амьдрал суугаа гэрийг «улсын», «нэгдлийн», «амины» гэж ялгаж тус тусад нь тоолно:**

а) **улсын гэрт улс,** олон нийтийн байгууллагын (яам, тусгай газар, үйлдвэр, албан байгууллага, сангийн аж ахуй зэрэг) мэдэлд байдаг (улсын өмч) дээрх байгууллагуудаас ажилчин, албан хаагчид бусад хүмүүсийн авч хэрэглэж байгаа гэрүүдийг хамруулна;

б) **нэгдлийн гэрт хөдөө аж ахуйн нэгдэл, нэгдэл дундны хоршиооллын өмчид байдаг, нэгдэл, хоршиооллын гишүүд, ажилчин, албан хаагчид, бусад хүмүүс авч хэрэглэж байгаа гэрүүдийг хамруулна;**

в) **амины гэрт хувь хүмүүсийн амины өмчид байдаг гэрүүдийг хамруулна;**

г) **отрын гэрт малчдын отор хийхэд зориулагдсан, ашиглагдаж байгаа гэрийг асууж зөвхөн тоогоор нь нөхнэ.**

**232. Гэрийн тоо** гэсэн үзүүлэлтэд тухайн айл өрхийн эзэмшиж байгаа гэрийн тоог (1, 2 гэх мэтээр) бичнэ. Хэрэв нэг өмчид хамрагдах өөр өөр ханатай 2 гэртэй бол ханын тоог нь дунджаар (бүхэл тоогоор) авч гэрийн тоог нь 2 гэж похло. **ЖИШЭЭ** нь: ижил өмчийн 5 ба 6 ханатай 2 гэртэй бол 1—3 дугаар мөрөнд аль тохиорох өмчийн дараа бичиж гэрийн тоог «2», ханын тоог 5 гэж нөхнэ.

**233. Суудаг өрх, байнга суугчдын тоо.** 1 дугээр өр-

хийн хувьд тухайн гэрт амьдардаг бүх өрх, байнга суугчдын нийт тоог нэмж суудаг өрх, байнга суугчдын тоог нөхсөн. Бусад өрхийн хувьд өрхийн тоо «1», байнга суугчид нь зөвхөн тэр өрхийн гишүүдээс байнга суугчдын тоотой тэнцүү байна.

234. Цахилгаан гэрэлтэй гэдэг асуултад «бий-1», «үүгүй-0» гэж бичнэ.

#### в) зуслангийн байшины

235. Айл өрх бүрээс тоологч нар зуслангийн байшинтай эсэхийг заавал асууж холбогдох үзүүлэлтийг нөхсөн байна.

236. «Тоо» гэсэн үзүүлэлтэд зуслангийн байшигийн тоог (1, 2 гэх мэт) бичнэ. Хот, суурин газарт амьдардаг айл өрхийн хашаанд байдаг, дулаан улиралд суудаг байшиг зуслангийн байшинд тооцохгүй.

237. Ашигтай талбай. Зуслангийн сууцны нийт талбай ашигтай талбай гэсэн үзүүлэлтэд нөхсөн байна.

238. Суудаг өрхийн тоо гэсэн үзүүлэлтэд зүны улиралд тухайн зуслангийн сууданд амьдардаг өрх айлын тоог бичнэ.

#### ДОЛОО. БНМАУ-ын хүн амын 1989 оны тооллогын урьдчилсан дүнг гаргах заавар

239. Сум, хороо, орон нутгийн хотын тооллогын комисс бүр хүн амын 1989 оны тооллогын урьдчилсан дүнг маягт УД-1, 2, 3, 4, СУД-1-ээр тус бүрийг 3 хувь гаргаж, 1 хувийг өөртөө авч, 2 хувийг аймаг, хотын хүн ам, орон суудны тооллогын орон тооны бус түр товчоонд тооллогын материалын (тооллогын хуудас, өрхийн хуудас, шалгалтын хуудас, хөдөлмөрийн насын хөдөлмөрийн чадвартай хүн амаас нийгмийн зохион байгуулалттай хөдөлмөр эрхлээгүй байгаа хүний судалгааны хуудас, эмэгтэйчүүдийн судалгааны хуудас, тооллогын ажилтны анкет) хамт бие хүнээр хүргүүлж тушаана.

240. Аймаг, хотын хүн ам, орон суудны тооллогын орон тооны бус түр товчоо, сум, хороо, район, орон нутгийн хотуудын тооллогын комиссоос хүлээж авсан урьдчилсан дүнг аймаг, хотын хэмжээгээр 2 хувь нэгтгэж, 1 хувийг өөртөө авч 1 хувийг Төлөвлөгөө, эдийн засгийн улсын хорооны Хүн амын тооллогын тасагт, сум, хороо, район, орон нутгийн хотуудаас гаргаж ирүүлсэн урьдчилсан дүн (УД-1, 2, 3, 4, СУД-1), тооллогын материалын хамт бие хүнээр хүргүүлж, хүлээлгэн өгнө.

241. Аймаг, хот сум, хороо, район, орон нутгийн хотын тооллогын комиссууд хүн амын 1989 оны тооллогын урьдчилсан дүнг гаргах, хүлээлгэн өгөхдөө дараах графикийг баримтлана. Үүнд:

Урьдчилсан дүнг гаргах хугацаа	Аймаг, хотын тооллогын түр товчоонд хүлээлгэн өгөх хугацаа	ТЭЗҮХ-ны хүн амын тооллогын тасагт хүлээлгэн өгөх хугацаа
1. Сум, хороо, район, орон нутгийн хотын тооллогын комисс	1 дүгээр сарын 12—15	1 дүгээр сарын 16—20
2. Аймаг, хотын тооллогын комисс	1 дүгээр сарын 21—25	1 дүгээр сарын 26-наас 2 дугаар сарын 5

#### 7. 1. Хүн амын тоог урьдчилсан дүгийн маягт УД-1-ээр гаргах заавар

242. Аймаг, хот, сум, хороо, район, орон нутгийн хотууд өөрийн тоологдсон хүн амын тоог урьдчилсан дүгийн маягт УД-1-ээр:

- Бүгд;
- Хотын;
- Хөдөөгийн хүн ам гэж 3 хүснэгтээр гаргана.

243. Тооллогын хуудасны хоёрдугаар асуултад «байнга суудаг» (энэ зааврын 109 дүгээрт заасан хүмүүс), «түр суугаа» (энэ зааврын 111 дүгээрт заасан хүмүүс) гэж хариулсан эрэгтэй хүний тоог 6 дугаар, эмэгтэй хүний тоог 11 дүгээр багананд нас бүрээр тоолж бичнэ.

244. Тооллогын хуудасны хоёрдугаар асуултад зөвхөн «түр суугаа» гэж хариулсан эрэгтэй хүний тоог 7 дугаар, эмэгтэй хүний тоог 12 дугаар багананд нас бүрээр тоолж бичнэ.

245. Тооллогын хуудасны хоёрдугаар асуултад «байнга суудаг», «түр эзгүй» гэж хариулсан эрэгтэй хүний тоог

**8 дугаар, эмэгтэй хүний тоог 13 дугаар багананд нас бураар тоолж бичнэ.**

**246.** Тооллогын хуудасны хоёрдугаар асуултад зөвхөн «түр эзгүй» гэж хариулсан эрэгтэй хүний тоог 9 дүгээр, эмэгтэй хүний тоог 14 дүгээр багананд нас бүрээр тоолж бичнэ.

**247.** Тооллогын хуудасны зургаадугаар асуултад (аль улсын харьяат) «Монгол» гэж хариулсан байнга суудаг (тооллогын хуудасны хоёрдугаар асуултад «байнга суудаг», «түр эзгүй» гэж хариулсан) хүмүүсийн дотроос эрэгтэй хүний тоог 10 дугаар, эмэгтэй хүний тоог 15 дугаар багананд тоолж бичнэ.

**248.** Хүснэгтийн насны бүлгийн дүн (0—4,5—9... гэх мэт), бүгд дүн (1, 2, 3, 4, 5 дугаар багана), хүн амын нийт тоо (86 дугаар мөрийн дүн) сум, хороо, район, орон нутгийн бүгд дүн (хот, хөдөөгийн нийлбэр)-г гаргаж, тооллогын хуудасныхаа тоотой тулгаж шалгана.

### **7. 2. Хүн амын нийгмийн бүлэг, боловсрол, харьяаллын байдал, өрхийн тоог урьдчилсан дүнгийн маягт УД-2-оор гаргах заавар**

**249. Нийгмийн бүлэг.** Тооллогын хуудасны аравдугаар асуултын (нийгмийн бүлэг) хариултыг үндэслэн гаргана. 1, 2, 3, 4, 5, 6-дугаар баганын дүнгүүд нь (5 дугаар мөр) урьдчилсан дүнгийн маягт УД-1-ийн «бүгд» хүснэгтийн харгалзах баганын (1, 6, 11, 3, 8, 13) дүнгүүдтэй-тохиорч байна.

**250. Гэрлэлтийн байдал.** Тооллогын хуудасны дөрөвдүгээр асуулт (нас) арван дөрөвдүгээр асуултын (гэрлэлтийн байдал) хариултыг үндэслэн байнга суудаг (хоёрдугаар асуултад байнга суудаг, түр эзгүй гэж хариулсан) хүн амаар гаргана.

**251. Боловсрол.** Тооллогын хуудсны арван хоёрдугаар асуултын (боловсрол) хариултыг үндэслэн хүн амыг хот, хөдөө дотор нь эрэгтэй, эмэгтэйгээр нь ангилж байнга суудаг хүн амаар гаргана.

**ТАЙЛБАР:** Энэ зааврын 187 дугаар зүйлд заасан хүүхдүүд боловсрол гэдэг үзүүлэлтийг бөглөхгүй учир дунд орохгүй.

**252. Өрхийн тоо.** Өрхийн хуудасны (маягт ХАТ-2) өрхийн ам бүлийн тоо гэсэн үзүүлэлтийг үндэслэн өрхийг

хот, хөдөөгөөр ангилж, ам бүлийнх нь тоогоор бүлэглэж гаргана.

**253. Улсын харьяалал.** Тооллогын хуудасны зургаадугаар асуултын (аль улсын харьяат) хариултыг үндэслэн бэлэн хүн ам (байнга суудаг, түр суугаа хүмүүсийн тооны нийлбэр), байнга хүн ам (байнга суудаг, түр эзгүй хүмүүсийн тооны нийлбэр)-аар ангилж гаргана.

**254. БНМАУ-ын харьяят** байнга суудаг хүний тоо (27 дугаар мөрийн 2 дугаар багана), бэлэн байгаа ба байнга суудаг хүн амын дүн (31 дүгээр мөрийн 1, 2 дугаар баганын тоо) нь урьдчилсан дүнгийн маягт УД-1-ээр гарсан дүн (хот, хөдөөг нэмж гаргасан сум, хороо, орон нутгийн хотын бүгд дүнгийн 86 дугаар мөрийн харгалзан 5, 1, 3 дугаар баганын дүн)-тэй тохиорч байна.

### **7. 3. Хүн амын ажил эрхлэлтийг урьдчилсан дүнгийн маягт УД-3-аар гаргах заавар**

**255.** Энэ маягтаар зөвхөн байнга суудаг хүн амын ажил эрхлэлтийн байдлыг гаргана. Тооллогын хуудасны 3, 4, 7, 8, 11 дүгээр асуултын (эрэгтэй, эмэгтэй, нас, ажилладаг байгууллага, эрхэлдэг ажил, амьдралын эх сурвалж) хариултыг үндэслэн бүгд дүнг дотор нь хот, хөдөө, эрэгтэй, эмэгтэйгээр нь ангилан нас, улс ардын аж ахуйн салбаар бүлэглэж гаргана.

**256.** Байгууллагыг (зарим тохиолдолд тодорхой ажил эрхлэлт) улс ардын аж ахуйн зоих салбарт оруулахдаа статистикийн төв газраас (хуучин нэрээр) 1987 онд баталсан хөдөлмөрийн неөцийн балансыг зохион зааврыг баримтлана.

Амины туслах аж ахуйдаа ажиллагчдыг хөдөө аж ахуйн салбарт, хөдөлмөрийн нехөрлөл (хоршоолол)-д ажиллагчдыг эрхэлдэг хөдөлмөрийн шинжээр нь аль тохиорх улс ардын аж ахуйн салбарт оруулна.

Түр хугацаагаар өөр газарт албан үүрэг гүйцэтгэж байгаа зарим хүмүүс, захиргааны чөлөөтэй, ээлжийн амралттай, хөдөлмөрийн чадвар түр алдсан хүмүүс, жирэмсний ба төрсний дараах амралттай, хүүхдээ асрахаар чөлөөтэй байгаа эхчүүд, өөр ажилд шилжихээр ажлаасаа чөлөөлөгдөөд түр ажилгүй байгаа, жижиг танхайн хөргээр 30 хүртэл хоногоор баривчлагдсан хүмүүсийг ажил эрхлээгүй гэж үзэхгүй урьд өмнө нь хийж байсан ажлыг нь харгалзан зоих улс ардын аж ахуйн салбаруудад нь оруулна.

Харин хөдөлмөрийн насын хөдөлмөрийн чадвартай хүн амаас нийгмийн зохион байгуулалттай хөдөлмөр эрхлээгүй байгаа хүмүүс, хувиараа хөдөлмөр эрхэлдэг гар урчууд, чөлөөт мэргэжлийн хүмүүс, бусдад хөлсөөр ажил хийгчдийг тодорхой ажил эрхэлдэггүй гэдэгт оруулна.

**7. 4. Сум, хороо, орон нутгийн хотын хүн амын тоог урьдчилсан дүнгийн маягт УД-4-өөр гаргах заавар**

257. Тооллогын хуудасны хаягийн хэсэг (хотын хаяг, хөдөөгийн хаяг) болон 2,3 дугаар асуултын (байнга суудаг, түр эзгүй, эрэгтэй эмэгтэй) хариултыг үндэслэн зөвхөн байнга суудаг (байнга суудаг, түр эзгүй байгаа хүмүүсийн нийлбэр) хүн амаар гаргана.

258. Маягтын «а» хэсэгт сум (хороо)-ын (хөдөөгийн хаяг-2 гэж зурсан) хүн амыг, «б» хэсэгт хот, хот маягийн суурингийн (энэ зааврын 4 дүгээр хавсралтыг баримтлан хотын хаяг-1 гэж зурсан) хүн амыг ялгаж гаргана.

259. Сумын нэрийг БНМАУ-ын АИХТ-ийн зарлигаар баталснаар бичнэ.

260. Тооллогын хуудасны «хөдөөгийн хаяг» хэсэгт сум (хороо)-ын төвд, бригад, хэсэг, фермийн төвд, хөдөөд гэдгийн зурагдсан байдлаар ялгаж, эрэгтэй, эмэгтэйгээр нь тоолж бичнэ.

**7. 5. Амины байшин, гэр, зуслангийн байшигийн тоог урьдчилсан дүнгийн маягт СУД-1-ээр гаргах заавар**

261. Амины байшин, гэр, зуслангийн байшигийн урьдчилсан тоог өрхийн хуудас (маягт ХАТ-2)-ны орон сууцны үзүүлэлтүүдийн хариултыг үндэслэн гаргана.

262. **Өвлийн байшин.** Өрхийн хуудасны орон сууцны асуултын «А» хэсгийн (байшин-1) «сууцны доторх өрхийн дараалал» гэсэн асуултад «1», «байшигийн өмчийн хэлбэр» гэсэн асуултад «5» ба «6» гэж хариулсан өрхүүдийн орон сууцны байшигийн тоог өрөөний тоогоор нь бүлэглэж тоолоод ашигтай ба сууцны талбайн хэмжээ, сууж буй өрх, байнга суугчдын тоог нэмж гаргана.

263. **Гэр.** Өрхийн хуудасны орон сууцны асуултын «Б» хэсгийн (Гэр-2) «гэрийн доторх өрхийн дараалал» гэсэн асуултад 1, гэрийн өмчийн хэлбэрийг «амины» (03 дугаар мөр) гэж хариулсан өрхүүдийн гэрийн тоог ханын тоо-

гоор нь бүлэглэж тоолоод, сууж буй өрх, байнга суугчдын тоог нь нэмж гаргана.

Харин маягт ХАТ-2-ын гэрийн хэсгийн отрын гэр (4 мөр)-ийн тоог нэмж 10 дугаар мөрийн «бүгд» багасанд бичнэ. Энэ дун нь гэр-бүгд гэсэн 6 дугаар мөрийн дунд орохгүй.

264. **Зуслангийн байшин.** Өрхийн хуудасны орон сууцасуултын «В» хэсгийн (зуслангийн байшин-3) асуултад хариулсан бүх өрхийн хувьд зуслангийн байшигийн тоо, ашигтай талбайн хэмжээ, суудаг өрхийн тоог шууд нэмж гаргана.

**ТӨЛӨВЛӨГӨӨ. ЭДИЙН ЗАСГИЙН УЛСЫН  
ХОРООНЫ ХҮН АМЫН ТООЛЛОГЫН  
ТАСАГ**

## Хавсралт № 1

### ХҮН АМЫН ТООЛЛОГЫН ХУУДАСНЫ НӨХӨЛТИЙН ҮНЭН ЗӨВИЙГ ШАЛГАХАД АНХААРАХ ЗАРИМ ЗҮЙЛ

1. Тооллогын хуудасны асуулт бүр (эрэгтэйчүүдэд 15 дугаар асуултаас бусад) хариулагдсан байх ёстой.

2. Тоологч бүр нөхсөн тооллогын хуудсаа 1-ээс эхлэн дэс дараалан дугаарласан байна. Тооллогын сүүлчийн хуудасны дугаар тухайн тоологчийн тоолсон хүний тоотой тэнцүү.

3. Тооллогын комисс, хэсгийн дугаарыг Төлөвлөгөө, эдийн засгийн улсын хорооноос хуваарилж, хүргүүлснээс өөрөөр бичиж хэрхэвч болохгүй.

4. Аймаг, хот, сум, хороо, район, орон нутгийн хотын нэрийг зохих асуулт бүрийн (хаягийн хэсэг, 2, 4 дүгээр асуулт) дараа гаргацтай бичиж ард нь зохих кодыг 3 дугаар хавсралт (хот маягийн суурингийн хувьд 4 дүгээр хавсралт)-аас харж бичсэн байна.

Хот, хөдөогийн хаягийн зөвхөн аль нэг нь нөхөгдөнө. Эрхийн хуудасны хаягтай тохирно.

5. Регистрийн дугаар аваагүй хүний хувьд регистрийн дугаарыг бичих зайны доод талын нүдэнд 1 гэж заавал бичсэн байх ёстой.

6. Нэг тоологч (хэсэг)-ийн тоолсон өрхийн тоо, өрхийн хуудас нээсэн (дотуур байранд судаг оюутан сурагчид, нийтийн байранд суудаг ажилчдад нээж, орон сууцны асуудлыг нь нөхсөн өрхийн хуудсыг тооцохгүйгээр) өрхийн тоотой тэнцүү. Нэг өрхийн ам бүлийн гишүүдэд нөхсөн тооллогын хуудасны өрхийн № ижил байна.

7. Тооллогын хуудасны асуултын хариулт нь өрхийн хуудасны зохих асуултын хариулттай ижил байна. Тухайлбал: хаягийн хэсэг, өрхийн дугаар, овог нэр, нас, эрэгтэй, эмэгтэй, байнга суудаг, түр өзгүй, түр суугаа, нийгмийн бүлэг, гэрлэлтийн байдал, эрхэлдэг ажил, амьдралын эх сурвалж, өрхийн тэргүүлэгчтэй ямар хамааралтай болох.

8. Өрхийн тэргүүлэгчтэй ямар хамааралтай болох гэ-

сэн асуултад өгсөн хариултыг бусад асуултын хариулттай уялдуулан шалгана. Үнд:

а) хэрэв нөхөр, хүү, эцэг гэх мэт эрэгтэй хүнд хамаархаар хариулсан бол 3 дугаар асуултыг эрэгтэй-1 гэж, хэрэв эхнэр, охин, эгч, хадам эх гэх мэт эмэгтэй хүнд хамаархаар хариулсан бол 3 дугаар асуултад эмэгтэй-2 гэж хариулсан байх ёстой;

б) тэргүүлэгч өөрөө гэж хариулсан хүн 16-аас доош настай байж болохгүй.

9. Түр суугаа гэж хариулсан хүн бүрийн байглаа суудаг хаяг заавал нөхөгдөж код тавигдсан байна.

10. Эмэгтэй-2 гэж 3 дугаар асуултад хариулсан 18-аас дээш настын эмэгтэйчүүд 15 дугаар асуултыг заавал хариулсан байна.

11. 4 дүгээр асуултын хариултыг шалгахдаа дараах зүйлийг анхаарна. Үнд:

а) насыг зөв тодорхойлсон эсэх;

б) аймаг (хот), сум (район)-ын кодыг тавьсан эсэх;

в) наас, боловсролын төвшин уялдсан эсэх;

г) нас, гэрлэлтийн байдлын хариулт уялдсан байдал;

д) эмэгтэйчүүдийн хувьд нас, төрүүлсэн хүүхдийн тооны уялдаа.

12. Яс үндэс, аль улсын харьят гэсэн үзүүлэлтийг зааврын дагуу бөглөж шифрийг нь ард нь тавьсан эсэх.

13. Ажилладаг байгууллага, суралцдаг сургууль, эрхэлдэг ажил, амьдралын (орлогын) эх сурвалж гэсэн асуултуудын хариултыг хооронд нь уялдуулан шалгана.

14. Нийгмийн гарлыг шалгахдаа тэр хүний насыг сайн анхаарах хэрэгтэй. ЖИШЭЭ нь: 35-аас доош настын хүмүүсийн хувьд ихэвчлэн малчин ард биш, хоршоолсон ард, (одоо нэгдэл мал маллаж байгаа малчдын хүүхдийн нийгмийн гарал мэн хоршоолсон ард) гэж байна.

15. Нийгмийн бүлгийг уг хүний ажил эрхлэлтийг нь үндэслэн тодорхойлно. Нийгмийн бүлгийг нь тодорхойлоход бэрхшээлтэй зарим ажил эрхлэлтийг хавсралт № 9-ees үзэх хэрэгтэй.

**ажилладаг байгууллага, эрхэлдэг ажил, амьдралын (орлогын) эх сурвалж гэсэн асуултын зарим хариултыг схемчлэн жишээ болгож үзүүлбээс:**

Ажилладаг байгууллага, суралцдаг сургууль	Эрхэлдэг ажил	Амьдралын (орлогын) эх үүсвэр
A	1	2
1. Үйлдвэр, аж ахуй, албан байгууллагын нэр	уг хүний эрхэлж байгаа ажил	Үйлдвэр, аж ахуйн газар, албан байгууллага-1
2. Хөдөө аж ахуйн нэгдэл, цэгдээт дундын үйлдвэр, хоршооллын нэр	—“—	хөдөө аж ахуйн нэгдэл-2
3. Өндөр насын тэтгэвэрт	өндөр насыны тэтгэвэр	өндөр насыны тэтгэвэр-3
4. Их, дээд, тусгай мэргэжлийн дунд, техник мэргэжлийн сургууль, түүнтэй адил суралцдаг сурагчид нь стипенди авдаг сургууль, курсын нэр	... р курс (анги)-ийн оюутан (сурагч, сонсогч)	стипенди-4
5. Улсын бусад тэтгэвэр	улсын бусад тэтгэвэр	улсын бусад тэтгэвэр-б
6. Бусдын асрамж (сургуулийн ёмнох насын хүүхэд, тэтгэвэр авдаггүй хөдөлмөрийн наас хэтэрсэн (эрэгтэй 60-аас, змэгтэй 55-аас дээш настай) хүмүүс, төрөлхийн тахир дутуу, оюуны хомсдолтой хүмүүс, хөдөлмөрийн насын боловч зарим хүндэтгэх шалтгаанаар нийгмийн зохион байгуулалттай хөдөлмөр эрхлээгүй хувь хүний асрамжинд байгчид).	бусдын асрамжинд	өрхийн тэргүүлэгч, асран хамгаалагчтай адил

A	1	2
7. Амины туслах аж ахуй (амины туслах аж ахуй эрхэлдэг нэгдэлчид, туслах аж ахуй эрхэлдэг ажилчин, албан хаагчид тэдгээрийн гэр бүлийн хүмүүс)	эрхэлтэг ажлын нээ	амины туслах аж ахуй, хувийн хөдөлмөр-7
8. Хөдөлмөрийн нөхөрлөл (хоршоолол)-ийн нэр	эрхэлдэг ажлын нэр	хөдөлмөрийн нөхөрлөл (хоршоолол)-8

16. Боловсролын төвшингийн хариултыг шалгахад дараах зүйлийг анхаарах хэрэгтэй. Үүнд:

- а) сургуульд ороогүй хүүхэд уг асуултад хариулахгүй;
- б) сургуулийн насын боловч төрөлхийн тахир дутуу, оюуны хомсдолтойн улмаас сургуульд ороогүй 9-өөс доош насын хүүхэд мөн хариулахгүй;

в) 1—3 дугаар ангийн сурагчид «бичиг мэддэг», 4—8 дугаар ангийн сурагчид «Бага», 9—10 дугаар ангийн сурагчид «бүрэн бус дунд», 10 дугаар анги төгсөөд их, дээд сургуулийн 1, 3 дугаар курс, техникум, ТМС-д суралцагчид «бүрэн дунд», их, дээд сургуулийн 3-аас дээш курсын оюутнууд «бүрэн бус дээд» гэж тус тус хариулсан байх ёстой.

17. Гэрлэлтийн байдлыг 18 түүнээс дээш насын бүх хүн заавал хариулсан байна. Хүүхдүүдийн хувьд хариулагдахгүй. 16, 17 насын зарим хүн энэ асуултад хариулсан байж болно.

18. Төрүүлсэн хүүхдийн тоог зааврын дагуу бөглесэн эсэх, одоо энх тухи амьдарч байгаа хүүхдийнх нь тоог нас, хаана амьдарч байгааг харгалзангуй нийт төрүүлсэн хүүхдээс нь сугалж харуулсан эсэхийг шалгана.

## Хавсралт № 2

### ӨРХИЙН ХУУДСЫГ ШАЛГАХАД АНХААРАХ ЗАРИМ ЗҮЙЛ

1. Аймаг (хот), сум (хороо, район)-ын нэрийг гаргацтай бичиж, кодыг зөв тавьсан байна.

2. Тооллогын комисс, хэсгийн дугаарыг Төлөвлөгөө, эдийн засгийн улсын хорооноос хуваарилан хүргүүлснээс өөрөөр бичиж хэрхэвч болохгүй.

3. Өрхийн ам бүлийн тоо, тооллогод хамрагдсан өрхийн ам бүлийн гишүүдийн тоотой тэнцүү эсэх, хэрэв илүү дутуу байгаа бол шалтгааныг тодруулах (түр суугаа хүний тоогоор дутаж, гадаад дотоодод суралцаж байгаа буюу цэргийн алба хааж байгаа зайлшгүй тэр өрхийн ам бүлд байх хүний тоогоор илүү гарч болох юм).

